

Ногоон хөгжлийн төлөө

# MONGOLIAN ECONOMY

2014 ОНЫ 11 САР, №18 (076)

ЭДИЙН ЗАСАГ  
СОНГОЛТЫГ ИРГЭДЭД ҮЛДЭЭ

ТАТВАР  
ЦАГ АЛДСААР, ОРЛОГО ТАСАРСААР

ХӨГЖЛИЙН ГАЙХАМШИГ  
БООЛООС “БОСС” ОРОН

WWW.MONGOLIANECONOMY.MN

Бид сонголт хиймээр  
байна!

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭМГЭГ ТОГТОЛЦОО





**BOSE**<sup>®</sup>  
Better sound through research<sup>®</sup>

Хөгжим танд маш  
ихийг өгүүлдэг.  
Та харин алдахгүй  
сонсож чаддаг уу?

**NEW**  
SoundTrue™ ЧИХЭВЧ  
around-ear headphones




АЛБАН ЁСНЫ ДИСТРИБЬЮТОР:

**PC mall**<sup>®</sup>



# WWW.PC-MALL.MN

ОНЛАЙН ДЭЛГҮҮР



- ОНЛАЙН ЗЭЭЛ
- БҮХ БАРАА 3% ХЯМДРАЛТАЙ
- ТӨЛБӨРӨӨ БЭЛНЭЭР ТӨЛӨХ БОЛОМЖ
- ХҮРГЭЛТ ҮНЭГҮЙ

ОНЛАЙН ХУДАЛДААНЫ ШИНЭ ҮЕ..

## ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр / 9999-4248

## ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал / 8800-6228

## АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:

Ийланд Роберт Мэн

## ЗӨВЛӨХ МЭРГЭЖИЛТЭН:

Лиззи Хүү

## ВЭБ РЕДАКТОР:

Б.Энхцэцэг

## СЭТГҮҮЛЧИД:

Б.Баяртогтох

Э.Зоригт

Б.Үүрийнтуяа

С.Батзаяа

## ДИЗАЙНЕР:

Ш.Оюундарь

## МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.Бариянжав / 9409-2904

## “MONGOLIAN ECONOMY”

### СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

#### Б.БЯМБАСАЙХАН

Монголын бизнесийн зөвлөлийн ТУЗ-ийн дарга, "Mongolian Economy" сэтгүүлийн Зөвлөлийн тэргүүн

#### Б.БОЛД

"Рио Тинто" компанийн Зэсийн группын Олон улсын үйл ажиллагаа эрхэлсэн Ерөнхийлөгч

#### С.БЭХБАТ

ЭЗХЯ-ны Инноваци, төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга

#### Д.ЖАРГАЛСАЙХАН

МНН группын ерөнхийлөгч

#### Ц.БАТСҮХ

СЭЗДС-ийн Эдийн засгийн тэнхимийн эрхлэгч

#### Ж.СҮНЖИДМАА

"Пийбоди Энержи" компанийн Монгол дахь хамтын ажиллагаа, олон нийтийн асуудал хариуцсан менежер

#### Б.ТҮВШИНТӨГС

Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал

## ХАЯГ:

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг.

VI хороо, Их сургуулийн гудамж.

AB center. 504 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762

www.mongolianeconomy.mn

info@mongolianeconomy.mn

Утас/Факс: 976 - 7011 5476

"Улаанбаатар принт" ХХК-д хэвлэв

www.ubprint.mn

## ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС



Манай сэтгүүл энэ удаагийн дугаартаа Эрүүл мэндийн даатгалын асуудлыг онцоллоо. Жил гаруйн өмнө бид энэ сэдвээр хөндөж байсан. Байдал өнөөдөр огтхон ч дээрдээгүй бахь байдгаараа байгаа учраас Намрын чуулганаар хэлэлцэх Эрүүл мэндийн албан журмын даатгалын хуулийн төсөлтэй холбоотойгоор дахин бичиж байна. Бараг хоёр жилийн өмнө хэдэн УИХ-ын гишүүн Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн төсөл санаачилж, хэлэлцэж эхэлсэн ч хуулийн төслийн нэр өөрчлөгдсөнөөс

өөрөөр өнөөдрийг хүртэл нэг ч шат ахиагүй. Уг хуулийг энэ намрын чуулганаар батлах учиртай. Ямар нэртэй гарах нь хамаагүй хэрвээ тус хууль батлагдвал Монголын дампуу эрүүл мэндийн даатгалын тогтолцоонд жаахан ч гэсэн шинэчлэлийн салхи сэвэлзэж магадгүй гэсэн хүлээлт, горьдлого нийгэмд бий. Энэ талаар манайх тал талаас нь харсан дэлгэрэнгүй мэдээлэл хүргэж байгаа болно.

Энэ сэдэвтэй холбоотойгоор иргэн та юуны тулд эрүүл мэндийн даатгал төлдөг вэ гэсэн асуулт тавих хэрэгтэй болж байна. Хэлж ирдэггүй хийсч ирдэг өвчин эмгэгээс урьдчилан сэргийлж эрүүл мэндээ хамгаалуулах гэж, улмаар өвдөж зовсон үедээ эмнэлгийн үйлчилгээ авах гэж төлдөг бус уу? Үүний тулд эрүүл мэндийн даатгал оршдог. Сар бүр таны цалингийн хоёр хувийг, ажил олгогчоос тань ахиад мөн хувийг эрүүл мэндийн даатгалын шимтгэлд авдаг. Өнөөдөр дундаж орлоготой монгол хүн сарын 700 мянган төгрөгийн цалинтай гэж бодъё. Тэгвэл энэ хүн сар бүр эрүүл мэндийн даатгалын шимтгэлд өөрөөсөө 14000, ажил олгогчоосоо 14000 буюу нийт 28000 төгрөг өгч байгаа юм. Нэг жилд 336000 төгрөг эрүүл мэндээ хамгаалуулах гэж төлдөг гэсэн үг. Гэтэл үүнийхээ хариуд ямар эрүүл мэндийн үйлчилгээ авдаг билээ гээд бодоод үзэхээр тодорхой хариулт байхгүй. Бид огт өвддөггүй биш, өвддөг. Өвдөхөөрөө эрүүл мэндийн дэвтрийнхээ үр дүнг гаргахыг ялангуяа албаны ажилтай хүмүүс бараг боддоггүй. Цаг заваа бодоод улсын эмнэлгийн хаалгыг сахиж, урт дараалалд зогсохоос залхаж хурдан шуурхай үйлчилгээг нь бодоод хувийн эмнэлэгт хандах нь элбэг.

Гэтэл Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 6-д “эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно” гэсэн заалт бий. Ажилгүй, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон хүүхэд багачуудын эрүүл мэндийн даатгалыг төрөөс даадаг. Тэр мөнгө нь ажил орлоготой хүмүүсээс эрүүл мэндийн даатгалд авч байгаа мөнгөнөөс хэд дахин бага. Тодруулбал, сард 670 төгрөг, жилд 8040 төгрөг гээд бод доо. Гэтэл манай сэтгүүлчийн бичсэн нийтлэлд төрөөс дааж буй иргэдийн шимтгэл өнгөрсөн онд Эрүүл мэндийн даатгалын сангийн зургаан хувийг бүрдүүлжээ. Харин тэдэнд үзүүлсэн тусламж үйлчилгээний зардалд тус сангийн 59 хувийг зарцуулсан байна гэсэн баримт бий. Эндээс иргэн бүр эрүүл мэндээ хамгаалуулах эрхтэй гэсэн Үндсэн хуулийн заалт хэрэгжихгүй байгаа нь бэлхнээ харагдах ажгуу. Нэг үгээр төр үүрэх ёстой ачааныхаа тэн хагасаас илүүг нь ажил хөдөлмөр эрхэлж амьдралаа залгуулж яваа иргэдийн нуруун дээр үүрүүлж ирсэн ийм эрүүл бус тогтолцоог эвдсэн, ижил тэгш, илүү өргөн сонголттой, өрсөлдөөнтэй, шударга даатгалын системийг нийгэм шаардаж байна. Эрүүл мэндийн даатгалын сан гэсэн улстөрчдийн арааны шүлсийг асаруулж, сонирхлыг өдөөсөн ганцхан сантай, төлсөн шимтгэлийнхээ үр шимийг үзэхийн тулд түмэн олон зөвхөн улсын эмнэлэгт ханддаг байдал нь эрүүл мэндийн даатгалын учир утгыг алдагдуулж буй хэрэг юм. ▶

► Явал монголчууд гадаад орны иргэд шиг эрүүл мэндийн даатгал төлөхдөө аз жаргалтай байх вэ. Гадаадын олон оронд эрүүл мэндийн даатгалд хамрагдсан л бол уух эм, урьдчилан сэргийлэх үзлэг, хүнд өвчин туссан үед ч санаа зовох зүйлгүйгээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээг бүрэн даатгалаас даадаг байх жишээтэй. Даатгалын ид шидийг ингэж үзэж байгаа нөхцөлд даатгуулагч ч гэсэн мөнгө төгрөгөө эрүүл мэнддээ зарцуулахаас гар татах юун. Гэтэл манайд даатгалд төлж байгаа хэдэн төгрөг нь аманд ч үгүй хамарт ч үгүй болж, эрүүл мэндээ хамгаалуулж чадахгүй байна.

Хөгжил цэцэглэлтийн зам дээр зогсож буй Монгол Улс хүнийхээ эрүүл мэндэд зориулсан даатгалын тогтолцоотой болоход манай сэтгүүлийн зүгээс асуудалд гарц шийдэл хайсан олон талын байр суурь, бодит судалгаа дүгнэлттэй нийтлэлүүдийг байнга хүргэх болно. Эрүүл мэндийн асуудал эдийн засагтай шууд холбоотой учраас эрүүл мэнд манай сэтгүүлийн байнгын сэдэв гэдгийг хэлье.

## ДАРААГИЙН ДУГААРТ

Бид дараагийн буюу арваннэгдүгээр сарын 15-ны дугаартаа үнэт цаасны зах зээлийн мэдээллийг цогцоор нь хүргэнэ. Учир юу гэвээс, Монгол Улсад даатгалын салбар үүсэж хөгжөөд 80 жил болж байгаа бол Үнэт цаасны хороо буюу санхүүгийн салбарын нэгдсэн хяналт зохицуулалтын байгууллага үүсэн байгуулагдсаны 20 жилийн ой энэ онд тохиож байна. Үүнтэй холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хороотой хамтраад манай сэтгүүл үнэт цаасны зах зээлийн

мэдээллийг бүрэн цогцоор нь өгөх болно.

ИРО, бонд, хөрөнгө оруулалтын сан, даатгал, хадгаламж зээлийн хоршоо, ББСБ гээд үнэт цаасны зах зээлийн бүтээгдэхүүн үйчлилгээ, зах зээлд оролцогчдод тулгамдаж буй асуудал, салбарын хууль эрх зүйн орчин, хэтийн төлөв гээд олон асуудлыг уудлан бичих юм. Санхүүгийн зах зээлийн зохицуулалт, хөгжил түүхийг харуулсан сонирхолтой мэдээлэлтэй сэтгүүлээрээ эрхэм уншигч, захиалагч та бүхэнтэйгээ эргэн уулзъя.

Орлогч эрхлэгч И.ОТГОНЖАРГАЛ

## АГУУЛГА

### ЭДИЙН ЗАСАГ

#### 8 Сонголтыг иргэдэд үлдээ



“ P8

- 10 С.Одонтуяа: Эрүүл мэндийн салбар улс төрөөс хараат бус ажиллах ёстой
- 12 “Mongolian Economy” сэтгүүлийн асуулт
- 15 Даатгалын сан өндөр болох тусам үйлчлүүлэгчийн чанар сайжирдаг
- 18 НӨАТ-ын эргэн тойронд
- 20 Цаг алдсаар, орлого тасарсаар
- 22 Нөхөн сэргээлтийн жишиг
- 26 Боолоос “Босс” орон



“ P26

- 29 “Чингис” бондын зарцуулалт
- 30 Макро эдийн засгийг тогтворжуулах нь
- 33 Намуудын улс төр, нийгэм дэх үүрэг

 facebook.com/Mongolian.Economy

 youtube.com/user/MongolianEconomy

 twitter.com/EconomyMongolia

#### Борлуулах цэгүүд:

“Интер ном”  
 “Цэцэг төв”  
 “Минж плаза”  
 “Алтантүлхүүр” номын дэлгүүр  
 “Номин” супермаркетин бүх салбар

“Макс” супермаркетин бүх салбар

“Фреско” супермаркет

BTSI супермаркет

“Аз орчлон” номын дэлгүүр

“Билэг” их дэлгүүрийн номын тасаг

“Гранд Плаза” дахь супермаркет

“Мир” номын дэлгүүрийн

“Grand plaza”

“Metro mall”

“Sky” супермаркет

“Улаанбаатар” их дэлгүүр

“Max mall” дэх салбарууд

## МОНГОЛД



### Гадаад худалдаа

Монгол Улсын хэмжээнд өнгөрсөн есөн сарын байдлаар эрдэс баялгийн бүтээгдэхүүний экспортын алдагдал 24.4 сая ам.доллар болж өсчээ. Тодруулбал, 13.4 сая тонн нүүрс, 966 мянган тонн зэсийн баяжмал, таван сая баррель газрын тос, 80 мянган тонн цайрын хүдэр, 5.1 тонн алт тус тус экспортолсон байна. Өнгөрсөн оны эхний есөн сарын байдлаар 1.7 сая ам.долларын алдагдал хүлээж байжээ.

### Нийгэм

Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор “Залуучууд ба эв нэгдэл: Тэгш эрхийг хангахад залуучуудын оролцоо” сэдэвт Азийн залуучуудын чуулга уулзалтыг ирэх оны тавдугаар сарын 18-21-нд Улаанбаатар хотод зохион байгуулахаар болжээ.

Азийн залуучуудын зөвлөл нь бүсийн улс орнуудын залуучуудын байгууллагуудыг бэхжүүлэх зорилгоор байгуулагдсан аж. НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөлд зөвлөх статустай ажилладаг байгууллага юм байна.

### Хөрөнгийн зах зээл

Монголын хөрөнгийн бирж өдөр тутмын арилжааны болон ханшийн мэдээллийг гар утас, хөдөлгөөнт төхөөрөмжид зориулсан


мобайл апплейкешн гаргажээ. Тус программыг ашиглахын тулд App Store-д “MN Stocks” гэсэн апплейкешн суулгах аж.

“MN Stocks”-ыг ашигласнаар хэрэглэгч ханшийн мэдээллийг шуурхай хүлээн авахаас гадна өөрийн сонирхсон үнэт цаасаар багц үүсгэх боломжтой аж.

Тус программ ханш, тохиргоо гэсэн үндсэн хоёр хэсэгтэй байх бөгөөд хөрөнгийн зах зээлд оролцох, мэдээ мэдээллийг цаг алдалгүй хянах боломжийг олгож буй.

### Шинэ нисэх онгоцны буудал

Өнгөрсөн оны зургадугаар сард эхэлсэн Хөшигийн



хөндийн онгоцны шинэ нисэх буудлын барилгын ажил 25 хувийн гүйцэтгэлтэй байна. Одоогийн байдлаар оффис, 1200 ажилчны амьдрах байр, худаг, халаалтын зуух, цэвэрлэх байгууламж зэргийг байгуулж тохижуулсны зэрэгцээ бетон зуурмаг бэлтгэх гурван үйлдвэр, лабораторийн байр барьж, тоног төхөөрөмжийг угсарсан тухай Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төслийн зохицуулагч Н.Энхбат хэллээ. Гэрээнд зааснаар онгоцны буудлыг 2016 оны арванхоёрдугаар сард ашиглалтад оруулна.

### Төмөр зам

Энэ сарын 24-нд “Төрөөс төмөр замын бодлогын талаар баримтлах баримт бичиг”-ийг баталлаа. Төмөр замын тээврийн хамтын

ажиллагааны асуудлаар Хятадын талтай хийж буй хэлэлцээр амжилттай болсон тохиолдолд Тавантолгой-Гашуунсухайт, Сайншанд-Замын-Үүд, Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын шинэ шугамыг 1435 мм-ийн буюу нарийн царигтай барих юм. Харин Арц суурь-Эрдэнэт, Тавантолгой-Сайншанд-Баруун-Урт-Хөөт-Чойбалсан, Хөөт-Нөмрөг чиглэлийн төмөр замын шинэ шугамыг 1520 мм-ийн өргөн царигтай барих юм. Дэлхийн нийт төмөр замын 63 хувь нь нарийн буюу стандартынх. Харин 18 хувь нь өргөн буюу Орос стандартын төмөр замтай аж.

## ДЭЛХИЙ ДАХИНД

### Бээжин айлчлал

Улсын их хурлын дарга З.Энхболд Бээжинд айлчилж Хятадын Ардын их хурлын дарга Жан Дцзяантай уулзаж, хоёр орны хооронд хууль эрх зүйн хүрээнд дэх хамтын ажиллагааг өргөтгөх талаас хэлэлцээр өрнүүлжээ. Сүүлийн саруудад, Хятад хөрш 14 оронтой “Нөхөрлөл, итгэл, харилцан ашигтай хүртээмжтэй байдал” хэмээх шинэ гадаад бодлогынхоо хүрээнд дипломат харилцаагаа өргөтгөж буй. Их хурлын дарга нар харилцан ойлголцох санамж бичигт гарын үсэг зурж, Монгол болон Хятадын хууль тогтоогчдын хооронд харилцан үр ашигтай хамтран ажиллах гэрээг үзэглэжээ.

### Украины сонгууль

Барууны талыг баримтлагч намууд Украины Парламентад дийлэнх

суудлыг авч, Оросын талыг дэмжигчид буюу Коммунист намыг илт давуу ялжээ. Коммунист намаас ямар ч нэр дэшигч ялж чадаагүй нь Украины 100 жилийн түүхэнд гараагүй анхны томоохон бөгөөд гутамшигт ялагдал боллоо. Оросыг дэмжигчдийн зүгээс Украины сонгуулийг үймүүлэхийг оролдсон бөгөөд сонгууль өгөх байрууд хүртэлх замыг хаасан хэргээр салан тусгаарлагчид буруутгагдаж байна.

### Хятад Америкийг гүйцэж түрүүлээ



ОУВС-гийн гаргасан судалгаагаар, Худалдан авах чадварын харьцаагаар PPP/ нь үнэлбэл Хятад улс АНУ-ыг давсан байна. Энэ нь тухайлбал Хятадын мөнгөн тэмдэгт бусад орны амьдралын өртөгтэй хэр уялдаж, худалдан авах чадамж нь ямар байгааг гаргаж ирдэг, нэгдмэл үзүүлэлт юм. АНУ-ын хувьд 1872 оноос хойш худалдан авах чадварын харьцаагаар бусад орныг тэргүүлж ирсэн байдаг. Тус улс эдийн засгийн хэмжээгээр тэргүүлсэн хэвээр байгаа ч 2020 он гэхэд Хятадад гүйцэгдэнэ гэж олон улсын байгууллагууд үзээд буй.

### Сингапур амжилтаа бататгалаа

Дэлхийн банкны шинэ тайлангийн жагсаалтанд ес дэх жилдээ Сингапур бизнес хийхэд хамгийн таатай орноор шалгарлаа. Эхний 20 байрт шалгараад буй орнуудын хувьд бизнесийн орчноо үргэлжлүүлэн сайжруулж байгааг уг тайланд

онцолжээ. Мөн Дэлхийн банк хөгжиж буй эдийн засгууд бусад орны шилдэг туршлагаудыг бизнесийн орчиндоо тохируулан оруулж ирж, хууль эрх зүйн орчноо сайжруулж буй нь хурдан ахихад тусалж буйг тэмдэглэсэн байна. Азийн улсуудын хувьд Хонконг наймдугаарт, Өмнөд Солонгос тавдугаарт орсон бол 72 дугаар байрт Монгол улс оржээ. Дэлхийн банк Монголд хөрөнгө оруулагчдын хамгаалалтыг сайжруулж, татварыг зөөллөх зэрэг өөрчлөлтүүд авчирсны дүнд бизнесийн орчинд нь томоохон дэвшил гарсан гэж үзжээ.

#### АРЕС-ийн уулзалт болохоос өмнө



Ази номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны чуулган арваннэгдүгээр сарын 10-11-нд зохион байгуулагдаж, бүсийн нэгдэл, дэд бүтэц, худалдааны хөгжлийн асуудлуудаар голчлон ярицлахаар тогтоод буй. Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж тус чуулгантай холбогдуулан зохион байгуулж буй урьдчилсан хэлэлцүүлэгт Монголыг Ази номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын 22 дахь гишүүн болоход түлхэц өгөхөөр дэмжин оролцжээ. Монголыг тус байгууллагад элсэн орохыг Хятад, Орос улс хоёул дэмжиж байгааг есдүгээр сард Тажикстаны Душанбэд төрийн гурван өндөрлөг уулзах үеэр тэд илэрхийлжээ. ■



## # МОНГОЛ ЖИРГЭЭНИЙ ЕРТӨНЦӨД

Charlotte Simon @amneris987 – Oct 29

Хэрэглэгчийн зах зээл нь хамгийн хурдацтай хөгжиж буй зах зээлүүд 2014 онд <http://shar.es/10giQ5> #Малави, #Сьерро Леон, #Туркменистан #Саудын Араб #Монгол

*Дэлхийн хамгийн өндөр өсөлттэй хэрэглэгчийн зах зээлтэй орнуудын тавдугаарт бичигдэж буй Монголын зах зээл нь өнгөрсөн жилийн мөн үеийнхээс 12 хувиар энэ жил өсөх төлөв байна. Нэг хүнд ногдох зарцуулалт нь 1785 ам.долларт хүрч буй. Өнгөрсөн жилүүдэд тогтмол өндөр өсөлттэй байсан Монгол улс нь бага хүн амтай орон. Гэсэн ч дунд хугацаанд тус улсын хэрэглэгчийн зах зээл нь найдвар төрүүлэхүйц өндөр хүлээлттэй байгааг “Евромонитор” олон улсын байгууллага хэлж байна.*

MFA Mongolia @MFAMongolia\_eng Oct 27

Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банкыг байгууллахаар Монгол болон бусад 21 орон гарын үсэг зурлаа. [http://www.mfa.gov.mn/en/index.php?option=com\\_content&view=article&id=3546%3A memorandum-of-understanding-on-establishing-the-asian-infrastructure-investment-bank-signed&catid=94%3A2011-04-18-11-02-11&lang=en](http://www.mfa.gov.mn/en/index.php?option=com_content&view=article&id=3546%3A memorandum-of-understanding-on-establishing-the-asian-infrastructure-investment-bank-signed&catid=94%3A2011-04-18-11-02-11&lang=en) ...

*Хятадад Монголыг төлөөлөн суугаа Элчин сайд Ц.Сүхбаатар улсаа төлөөлөн аравдугаар сарын 24-нд Бээжинд Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк байгуулах ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурчээ. Азийн 22 орны төлөөлөл тус санамж бичигт гарын үсгээ зурсан байна. Тус банкыг Хятад улс тэргүүлж ажиллах бөгөөд бусад олон улсын банктай мөр зэрэгцэн ижил түвшинд үйл ажиллагаагаа явуулна. Хятад улсын зүгээс эхний ээлжийн хөрөнгийн эх үүсвэрийн дийлэнхийг буюу 50 тэрбум ам.долларыг өгөхөөр болжээ.*

Оюуны ЭРДЭНЭБУЛГАН @oerdenebulgan

Засгийн газрыг огцруулах сургаар #Монголын компаниудын индекс унаж бна. 0975 MMC -11.50 цагийн байдлаар 27.18% унаж бна

*Mongolian mining corporation компанийн хувьцаа огцом унасан байна. Уг уналтын гол шалтгаан нь Монголын нүүрсний уурхайнууд өрийн дарамтад орсонтой холбоотой гэнэ. Гэхдээ ганцхан өдрийн дотор тус компанийн хувьцаа 29 хувиар унасан нь Монгол Улсын Засгийн газар огцрох болон MMC хувьцаа нэмж гаргаж хуучин хувьцаануудын эзэмшлийн хувь буурах болсонтой холбоотой байж магадгүй аж.*

Г.Ганбат @g\_t:

Эрээ цээргүй эрх мэдэлтнүүд нэг зүйл тооцохгүй бна. Өлсгөлөнгийн өмнө хүн араатан болдог, дээр нь #Монголчууд өлсөж үзээгүй

@Asashoryu Asashoryu:

Ene Altanhuyag yaasan ih sandal shireeteigee zuuraldana ve!!!! Er hun shig ugchij boldogyi yumuu ain!!!!

Ganzaa @Ganzaa\_R:

Монгол төрийн түүхэн дэх хамгийн увайгүй, худалч, зальтай Ерөнхий сайдын үед бид амьдарч байна. Ичих булчирхай нь өөрөөс нь ичээд явцан

Enkhbat Dangaasuren:

Стрессгүй Жиргээ: 1) Үнэ цэнэгүй мэдээлэлтэйг бүү дага 2) Хэрэггүй харьцааг шууд блокол 3) List-ээр шүүж, бүлэглэж унш 4) Цаг бага зарцуул

ЭРҮҮЛ МЭНД

# СОНГОЛТЫГ ИРГЭДЭД ҮЛДЭЭ

С.БАТЗАЯА

Монголчууд жил бүр гадагшаа эмчилгээнд явах зардалд 70-120 орчим сая ам.доллар зарцуулж байна. Иргэд баталгаатай оношилгоо, эмчилгээ авахын тулд ийм их хэмжээний мөнгийг урсаж буй нь манайд эрүүл мэндийн салбар ямархуу түвшинд хөгжсөнийг илтгэх. Хүн бүр ажилтай, орлоготой байж сайхан амьдралыг цогцлоохын тулд эрүүл байх ёстой. Тиймээс өвдсөн үедээ эрүүл мэндийн үйлчилгээ авахын тулд сар бүр цалингаасаа тодорхой хэсгийг эрүүл мэндийн даатгалд төлдөг. Гэтэл үүнийхээ үр шимийг төдийлэн амсч чадахгүй байна. Энэ гаж тогтолцоог үндсээр нь өөрчлөх ёстой хэмээн сүүлийн үед төрийн болоод хувийн хэвшлийн байгууллагын зүгээс хүчтэй шүүмжлэх болсон. УИХ-ын өнгөрсөн хаврын чуулганаар үүнийг өөрчлөхөөр Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлсэн ч төсөл санаачлагчид нь буцаан татсан. Тэгвэл Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамнаас дахин шинэчлэн найруулж, Эрүүл мэндийн албан журмын даатгалын тухай болгон нэрийг нь өөрчлөн УИХ-д өргөн мэдүүлээд байна. Шинэ хуулиар дээр дурьдсан асуудлыг яаж зохицуулах, тэр нь хөрсөн дээр хэрхэн буух нь одоогоор тодорхойгүй байгаа.

Манай улсад дөрвөн хүн тутмын нэг нь элэгний В, С вирустэй гэсэн судалгаа бий. Бид эрүүл мэндийн даатгал төлдөг ч хоёр дахь шатлалын эмнэлэгт В, С вирустайгаа мэдэх гэж шинжилгээ өгөхдөө төлбөр төлдөг. Даатгал төлсний үр шимийг хүртэхгүй байгаа бодит жишээ энэ мэтээр цааш хөвөрнө. Манай сэтгүүл энэ асуудалд

Хоёр дахь нийгмийн даатгалтай болмоор байна. Энэ нь хувийнх эсвэл улсынх аль нь ч байж болно. Тэгэхээр үйлчилгээ үзүүлж буй байгууллагууд өрсөлддөг болно. Даатгал бол санхүүгийн үйлчилгээ юм.

гарц хайн, шийдэл нь юу байх, хэрхэн үр дүнд хүрэх талаар олон талын байр суурийг тусган хөндөж байгаа юм.

## Эв санааны зарчим мөн үү

Энэ оны улсын төсөвт эрүүл мэндийн салбарт 570 орчим тэрбум төгрөгийн санхүүжилт суулгажээ. Үүн дээр эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр 200 орчим тэрбум төгрөг нэмэгдэж байгаа аж. Өөрөөр хэлбэл, энэ жил тус салбарт 760-780 орчим тэрбум төгрөг зарцуулж буй. Гэхдээ энэ мөнгийг бараа үйлчилгээ худалдан авах болон эмнэлгүүдэд өгөөд /ор хоногоор санхүүждэг тогтолцоогоор явдаг учраас/ дуусдаг байна. Тодруулбал, улсын төсвөөс шимтгэлийг нь хариуцан төлдөг иргэд /ажилгүй, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон хүүхэд багачууд/ сард



670, жилд 8040 төгрөг төлдөг. Эдгээр иргэний төлсөн шимтгэл 2013 онд тус сангийн зургаан хувийг бүрдүүлжээ. Харин тэдэнд үзүүлсэн тусламж үйлчилгээний зардалд эрүүл мэндийн даатгалын сангийн 59 хувийг зарцуулсан байна. Харин албан байгууллагад ажиллаж буй иргэн сард дунджаар 16 мянга, жилд 192 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалд төлж буй аж. Энэ нь тэгш бус байдлыг бий болгож, эв санааны нэгдлийн зарчимд сөргөөр нөлөөлөх болсон гэж Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамныхан үзжээ.

Эрүүл мэндийн даатгалыг ийн харилцан адилгүй төлөх нь нэг талаараа шударга бус. Үүнийгээ төрөөс эв санааны нэгдлийн зарчим гэж тайлбарлах. Харин гурван хүн адил тэгш хэмжээтэй мөнгө нийлүүлээд түүнийгээ “ядарсан” үедээ эн тэнцүү авахыг эв санааны нэгдлийн ▶

▶ зарчим гэдэг аж. Тэгэхээр төр иргэдийн сонирхлыг нэг зүгт хандуулж чадахгүйн тод жишээ үүнээс харагдах. Одоо хүн бүр тэгш эрхтэй болох баталгааг бүрдүүлж өгөх хэрэгтэй байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас даатгуулагч үйлчилгээ авахдаа санхүүгийн эрсдэлээс төдийлэн хамгаалагддаггүй оношилгоо, шинжилгээ хийлгэх, хөнгөлөлттэй үнээр эм авах үйлчилгээ даатгалын тусламж, үйлчилгээний багцад



оновчтой бус байгаа аж. Өөрөөр хэлбэл, даатгуулагчийн өөрөөсөө төлөх төлбөр нэмэгдэж ядууралд өртөх эрсдэлд хүргэж байна гэж тус яам үзжээ. Энэ чиглэлийн судалгааг Азийн хөгжлийн банкнаас ч гаргасан байдаг. Тус банк иргэдийн дунд байгаа ядуурлын гол шалтгааныг эрүүл мэндийн салбартай холбон судалсан байна. Тэд тухайн хүний гэр бүлийнх нь гишүүдийн нэг нь гэнэтийн өвчин тусахад эмчлүүлэхийн тулд өөрт байгаа эд хогшлоо худалдаж буй нь ядуурлын нэг шалтгаан гэж дүгнэжээ. Манай одоогийн даатгалын систем ор, хоногоор санхүүждэг. Бусад улсад жилд нийт хүн амынх нь 3-8 хувь нь эмнэлэгт хэвтэн эмчлүүлдэг бол манайд энэ тоо 25-30 хувь. Учир нь, хэвтэх шаардлагагүй, өдрийн эмчилгээ хийлгэж болох хүмүүсийг хэвтүүлэн эмчилж, даатгалаас санхүүжилт авахыг боддог байна. Иймд эрүүл мэндийн даатгалын

тусламж, үйлчилгээний багцын нэр төрлийг өргөжүүлж даатгалын зардлын хамралтыг нэмэгдүүлэх шаардлагатай гэж шинээр боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлээд буй Эрүүл мэндийн албан журмын даатгалын тухай хуулийн төсөлд тусгажээ.

## Эрүүл мэндийн даатгалын санг өрсөлдөөнтэй болгоё

Эрүүл мэндийн салбарыг хүний биетэй зүйрлэж үзвэл дотор нь цус гүйж байгаа. Тэрхүү цус нь санхүү нь юм. Энэ урсгалыг бий болгоход эрүүл мэндийн даатгал хамгийн гол үүрэг гүйцэтгэдэг. Уг үйлчилгээг авахдаа сонголттой баймаар байна. Бид яагаад заавал даатгалын байцаагчид мөнгөө тушаах ёстой гэж. Энэ талаар хувийн хэвшлийн төлөөлөл "МН" группийн ерөнхийлөгч Д.Жаргалсайхан "Хоёр дахь нийгмийн даатгалтай болмоор байна. Энэ нь хувийнх эсвэл улсынх аль нь ч байж болно. Тэгэхээр үйлчилгээ үзүүлж буй байгууллагууд өрсөлддөг болно. Даатгал бол санхүүгийн үйлчилгээ юм. Өөрөөр хэлбэл, нийгмийн даатгалын санг задлаад хэд хэдэн байгууллага болгомоор байна. Олон болчихвол сонголттой болно. Одоо өрсөлдөөн байхгүй учраас буруу тогтолцоотой байна" гэв. Нийгмийн даатгалын санд сар бүр цалингаасаа өгч буй мөнгө биднийх. Бидэнд үйлчилгээ үзүүлэх гэж буй төрийн компанид төвлөрсөн энэ мөнгийг манайхан төсөвтэй хольж ирсэн. Одоо үүнийг салгах ёстойг тэрбээр нэмж хэлсэн.

Эрүүл мэндийн даатгалын сан Засгийн газрын үйл ажиллагаанд шууд зарцуулагдах татварын орлого бус харин даатгуулагчийг эрсдэлээс хамгаалах зорилготой хамтын мөнгөн хөрөнгө. Харамсалтай нь, энэ зарчим хэзээ ч биелж ирсэнгүй. Ажил хөдөлмөр эрхэлж байгаа нь сар бүр цалингаасаа хоёр хувь мөн тухайн байгууллага нь мөн хэмжээтэйгээр дунджаар сард 16, жилд 192 мянгыг төлж байна. Тэгсэн хэр нь хүнд өвчин тусахад эмнэлгийн үйлчилгээ, оношилгоог санасан хэмжээндээ авч чадахгүй байсаар. Тухайлбал, элэгний хорт хавдар сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж, улс эх орондоо насаараа зүтгэснээс эхлүүлээд Монголын

нэрийг дэлхийн тавцанд гаргаж яваа алдартнууд ч энэлэн шаналж байна. Тэд өнөөдөр иргэдээсээ эмчилгээний зардалдаа нэмэрлэхээр хандив цуглуулж байх жишээтэй. Гэхдээ энэ тэдний буруу биш, эрүүл мэндийн даатгалын тогтолцоо хүндээ чиглээгүйг илтгэх аж. Хөгжлийн түвшинээрээ хэдийнэ дундаж ангилалд багтах болсон Монгол Улсад эрүүл мэндийн салбар иймэрхүү байдалтай л хөгжиж байна. Одоогоор эрүүл мэндийн даатгалын байгууллага салбарын тусламж үйлчилгээний чанарт хяналт тавих замаар худалдан авах ▶

*Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо эрүүл бус буйг иргэд шүүмжилсээр ирсэн. Чухам юу нь болохгүй байгаа эсэх, хэрхэн зөв голдиролд оруулах боломжтой талаар "Mongolforum.mn" цахим хуудас жил орчмын өмнө иргэдийн дунд цахим хэлэлцүүлэг өрнүүлж байсан. Оролцогчдын заримынх нь санал бодлыг ишлэн хүргэе.*

- ЭМД-ын үр ашгийг бид даатгалаа төлөхдөө хэр аз жаргалтай байгаагаар тодорхойлж болно.
- Гайгүй сайн хувийн эмнэлгүүдэд даатгалаас санхүүжилт өгөх хэрэгтэй. Тэгвэл өрсөлдөөн сайжирч урт дараалал буурч магадгүй.
- Төр, хувийн хэвшилд даатгалын мөнгөнөөс хангамж өгдөг бол эрүүл мэндийн даатгал жинхэнэ утгаараа хэрэгжинэ.
- Төлсөн мөнгөнийхөө хэмжээгээр хуримтлал үүсгээд өөрийнхөө эмчилгээний зардлыг бүтэн төлчихдөг болгомоор байна.
- Өвдөхөөс урьдчилан сэргийлэх оношилгоонд, цаашлаад өвдсөн үед үгүдээ л өндөр үнэтэй шинжилгээ оношилгоонд хөнгөлөлт үзүүлдэг бол жинхэнэ утгаараа даатгал болох юм шиг санагддаг.
- Орчинд үед тухайн иргэн өөрийн хүссэн дурын эмнэлэгт эмчээ сонгож үзүүлэх бололцоог хангадаг болмоор байна.

► чадвар бүрдээгүй гэж Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамнаас боловсруулсан хуулийн төсөлд тусгажээ.

Эрүүл мэндийн салбарт шинэчлэл ингэж хийнэ гэсэн бэлэн жор алга гэдгийг хувийн хэвшлийн төлөөлөл хэлсэн. Гэхдээ жоргүй гээд явахгүйгээр цаашид явах чиглэл, багцаагаа гаргах ёстой. Ингэхдээ бусад улс орон ямар арга туршлага нэвтрүүлж хэрхэн үр дүнд хүрсэн талаар судлах хэрэгтэйг сануулсан. “Шийдвэр гаргагчдад байгаа эрх мэдлийг эмнэлгүүдэд шилжүүлж өгөх хэрэгтэй. Мөн тусламж үйлчилгээнд санхүүгийн эрх мэдлийг даатгалын байгууллагад нь өгвөл хөгжих учиртай” хэмээн эрүүл мэндийн эдийн засагч Ц.Нацагдорж хэлж байв. 1990-ээд оноос өмнө социалист

системээр явж байсан Эстони, Киргизстан зэрэг улс эрүүл мэндийн салбараа уялдаа холбоотой цогцоор нь хөгжүүлснээр амжилтад хүрчээ. Өөрөөр хэлбэл, манай одоогийн системээр явж байсан ихэнх улс эмнэлгийнхээ засаглалыг өөрчилсөн байдаг аж. Эмнэлгийг бие даалгаж, хүний нөөц, санхүү, менежмент зэргийг хэрхэн шийдэх тухай эрх мэдлийг өөрсдөд нь өгчээ. Энэ нь нэг талаар хариуцлагыг бий болгож, дор бүрнээ алдаа гаргахгүй ажиллах дадлыг бий болгосон байна.

Харин “МН” группийн ерөнхийлөгч Д.Жаргалсайхан “Хөгжлийн түвшин гэхээсээ илүүтэй аль ч орны сайн туршлагыг нэвтрүүлж болно. Тэр туршлага нь бидэнд нэмэр болох уу гэдгийг сонгохдоо тогтолцоо нь

нийгмийн гишүүдийн сонирхлыг нэг зүгт хандуулж чадаж буй эсэхийг харах нь чухал. Эрүүл мэндийн асуудал мөнхийн зүйл. Тиймээс иргэдийн сонирхлыг зөв хослуулах ёстой. Харин манайд энэ сонирхлыг зэрэг хослуулсан зүйл алга” гэв.

Эрүүл мэндийн даатгалыг төлсөн хэмжээнээсээ хамаарч тусламж үйлчилгээ харилцан адилгүй авч яагаад болохгүй гэж. Мөн үйлчилгээнүүд нь сонголттой байх ёстой. Өөрөөр хэлбэл, тухайн хүн эрүүл мэндийн даатгалаа төрд төлдөг бус хүссэн даатгалын компанидаа “өгөх” хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх хэрэгтэй байна. Ингэсэн цагт өнөө бидний яриад буй даатгал төлсний үр шим гарахгүй байна гэх улиг болсон яриа эцэс болох юм. ■

## ХУУЛЬ ТӨРӨХИЙН ӨМНӨ

# С.ОДОНТУЯА: ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР УЛС ТӨРӨӨС ХАРААТ БУС АЖИЛЛАХ ЁСТОЙ

С.ЗАЯА

УИХ-ын намрын чуулганаар Эрүүл мэндийн албан журмын даатгалын тухай хуулийн төслийг хэлэлцэнэ. Уг хуулийг боловсруулах ажлын хэсгийн ахлагчаар УИХ-ын гишүүн С.Одонтуяатай ажиллаж байна. Түүнтэй ярилцлаа.



**-Эрүүл мэндийн албан журмын даатгалын тухай хуулийн төслийн гол үзэл баримтлал юу вэ. УИХ-ын өнгөрсөн хаврын чуулганаар хэлэлцэж байсан Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулиас ямар ялгаатай вэ?**

-Засгийн газраас Эрүүл мэндийн албан журмын даатгалын тухай хуулийн төслийг өргөн барьсан. Үзэл баримтлалын хувьд өмнө нь Байнгын

хорооноос гаргасан ажлын хэсгийн гишүүдийн боловсруулж байсан хуулийн төсөлтэй зарчмын хувьд ижил, ганц нэг заалт нэмэгдэж, хасагдсан. Одоогийн өргөн барьсан хуулийн төсөл өмнөхөөсөө илүү сайжирч, бүх эмнэлэг, мэргэжлийн хүн, холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, иргэдээс санал авч тусгасан. Тиймээс УИХ-аас шинээр ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

**-Эрүүл мэндийн даатгал төлдөг ч хувь хүн өөрөөсөө зардал гаргаж, эмчилгээ авах нь одоогийн нөхцөл байдалд илүү байна. Хамгийн наад захын жишээ дурьдахад элэгний В, С вирусын шинжилгээг бид хоёр дахь шатлалын эмнэлэгт төлбөртэй өгдөг. Эрүүл мэндийн даатгал сар бүр цалингаасаа төлдөг ч үр шимийг нь хүртэж чадахгүй байна. Үүнийг хуулиар хэрхэн** ►

### ► зохицуулахаар тусгасан бол?

-Хуулийн төсөлд эрүүл мэндийн даатгалын сангаас зардлыг нь төлөх тусламж, үйлчилгээний хамрах хүрээг нэмэгдүүлсэн. Түүнчлэн даатгуулагч өөрөө сонгож үйлчлүүлсэн тохиолдолд эрүүл мэндийн байгууллагыг өмчийн хэлбэрээс нь үл хамааран ЭМД-ын сангаас ижил тарифаар хөнгөлөлт үзүүлэхээр төсөлд тусгасан байгаа.

**-Манай эрүүл мэндийн даатгалын тогтолцоо эв санааны нэгдлийн зарчмаар явж байгаа. Гэсэн ч шимтгэлийн хэт тэнцвэрт бус байдал тус салбарын хөгжилд чөдөр тушаа болж байх шиг. Үүнийг хэрхэн шийдэх вэ?**

-Дэлхийн олон улс орны эрүүл мэндийн даатгалын тогтолцоо эв санааны нэгдлийн зарчим руу шилжих

Бид энэ салбарыг олон жил эдийн засгийн нүдээр харахгүй ирсэн. Иргэн хүн өнөөдөр эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахын тулд өөрөөсөө 35-45 хувийг төлж байна. Харин дэлхийн жишигт 25 хувийг төлөхөд л ард иргэд санхүүгийн эрсдэлд орно гэсэн тооцоо байдаг.

хандлагатай байгаа. Учир нь, эрүүл мэндийн улмаас иргэдэд учирч буй санхүүгийн дарамт нэмэгдэж байна. Гэвч төрөөс шимтгэлийг нь хариуцан төлдөг иргэдийн ЭМД-д төлөх шимтгэлийн хэмжээ албан секторт ажилладаг аж ахуйн нэгжийн ажиллагсадынхаас хэд дахин доогуур байгаа. Хэдийгээр эрүүл мэндийн даатгалын эв санааны нэгдэл бүхий тогтолцоо нь иргэн бүр өөрийн орлогодоо үндэслэн хувь нэмэр оруулах ёстой ч сард төрөөс 670 төгрөгийн шимтгэл төлж байгаа нь хэт бага байгаа юм. Иймд хуулийн төсөлд төрөөс шимтгэлийг нь хариуцах иргэдийн шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан жил бүр тогтоож байхаар

тусгасан. Жишээ нь, шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний хоёр хувиар төлнө гэвэл сард 3844 төгрөг болно гэсэн үг.

**-Энэ онд эрүүл мэндийн салбарт зарцуулах мөнгийг ДНБ-тэй харьцуулахад 2.7 орчим хувь болж байгаа. Харин ДЭМБ аливаа улс ДНБ-ийхээ дор хаяж 7-9 хувьтай тэнцэхүйц санхүүжилтийг шийдэж байж эрүүл мэндийн салбараа авч явна гэсэн зөвлөмж гаргаж. Манай эрүүл мэндийн салбарын хөгжил хаана явна вэ?**

-Бусад орны статистик үзүүлэлтийг харахад, нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал Канадад 6000, ХБНГУ-д 4000, АНУ-д 8000 ам.доллар байдаг юм байна. ДНБ-ээс эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд зарцуулах хувь Канадад 11, ХБНГУ-д 11, АНУ-д 17 байх жишээтэй. Үүнээс гадна нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд ч нэлээдгүй мөнгийг зарцуулдаг. Харин манай улсад дор хаяж таваас доошгүй хувийн санхүүжилтийг шийдэж байж эрүүл мэндийн салбараа авч явна. Одоо 2.7 хувь байгаа нь бусад оронтой харьцуулахад үнэхээр доогуур үзүүлэлт л дээ.

**-Манайх эмнэлэгт хэвтэх шаардлагагүй, өдрийн эмчилгээ хийлгэж болох хүмүүсийг хэвтүүлэн эмчилж, даатгалаас санхүүжилт авахыг бодож байна. Үүнийг хуульд өөрчлөлт оруулах замаар шийдэх боломжтой юу?**

-Шийднэ. Хуулийн төсөлд бүх шатлалын эрүүл мэндийн байгууллагаас үзүүлсэн өдрийн эмчилгээнд ЭМД-ын сангаас санхүүжилт үзүүлэхээр оруулсан. Түүнчлэн өрхийн болон сумын эмнэлгийн өдрийн эмчилгээ, гэрээр үзүүлэх үйлчилгээнд хамрагдахад санхүүжилт олгохоор тусгаж байгаа.

**-Эрүүл мэндийн корпорацитай болохоор өмнөх хуулийн төсөлд тусгасан байсан. Энэ санал одоогийн төсөлд бий юу?**

-Энэ хуулийн төслөөр нэг худалдан авагчийн тогтолцоо руу бүрэн шилжих шилжилт хийгдэхгүй. Харин цаашид нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжих үндсэн нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

**-Салбарын санхүүжилтийн 70 хувийг улсын төсөв, үлдсэнийг нь даатгалаас өгч буй ч манайхан даатгал яриад байдаг. Бид бүх санхүүжилтээ нэг сангаар дамжуулж эмнэлгүүддээ өгдөг болох ёстой юм шиг ээ. Эндээс даатгалын байгууллага төсвийн мөнгийг яаж санд байршуулах вэ гэдэг асуудал гарч ирнэ. Энэ тал дээр та ямар бодолтой байна вэ?**

-Өмнө хэлсэнчлэн нэг худалдан авагчийн тогтолцоонд аажмаар шилжих утвар алхмаа хийж байна. Санхүүжилтээ нэг санд төвлөрүүлнэ гэдэг нь үндэсний эрүүл мэндийн даатгалын тогтолцоонд шилжинэ гэсэн үг. Үндэсний эрүүл мэндийн даатгал бол хамгийн зөв тогтолцоо боловч өнөөдөр шилжих утвар нөхцөл бэлэн биш байна. Цаашид татвар хураах систем, эрүүл мэндийн салбар, эмнэлгийн байгууллагуудын тогтолцооны шинэчлэлийг хийсний дараа нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжинэ гэж үзэж болно. Аливаа шинэчлэлийг нэг амьсгаагаар хийх нь олон эрсдэлийг дагуулдаг.

**-Ер нь эрүүл мэндийн салбарт ямар шинэчлэл хэрэгтэй байна вэ. Шинэчлэлийг ямар хэлбэрээр хийвэл илүү үр дүнтэй бол?**

-Бид энэ салбарыг олон жил эдийн засгийн нүдээр харахгүй ирсэн. Иргэн хүн өнөөдөр эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахын тулд өөрөөсөө 35-45 хувийг төлж байна. Харин дэлхийн жишигт 25 хувийг төлөхөд л ард иргэд санхүүгийн эрсдэлд орно гэсэн тооцоо байдаг. Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийг эрх зүйн орчны, санхүүгийн, хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмжийн, хүний нөөцийн шинэчлэл гэсэн дөрвөн үндсэн чиглэлээс эхлэх ёстой гэж бодож байна. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахын тулд юун түрүүнд төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагыг бизнесийн орчинд улс төрөөс хараат бусаар бие даасан тогтвортой ажиллах хууль эрх зүйн орчинг бий болгох ёстой. Энэ бол хувьчилна гэсэн ойлголт биш. Яагаад гэхээр манай төрөлжсөн эмнэлгүүдийн дийлэнх нь төрийн өмчит. Ингэхлээр өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагыг зах зээлийн харилцаанд тэгш оролцох боломжоор хангах, ►

▶ зөвхөн тусламж үйлчилгээнийхээ чанараар өрсөлдөх нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Эрх зүйн орчны шинэчлэлийн чухал хэсэг нь эрүүл мэндийн даатгалын тухай хууль. Гэвч дан ганц даатгалын хууль хангалттай биш. Манай хэсэг гишүүд хамтран Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зохион байгуулалтын тухай хуулийн төслийг боловсруулж дууслаа. Удахгүй өргөн барина. Энэ хуулийн амин чухал хэсэг нь эмнэлгийн засаглал, удирдлага, санхүүжилтийн асуудал юм.

**-Эмнэлгийн засаглал, бие даасан байдлыг сайжруулах талаар олон улсын туршлага хэр байдаг вэ?**

-1970-аад оноос дэлхийн олон оронд эмнэлгийн засаглал, бие даасан байдлыг сайжруулах оролдлогууд хийж байсан юм билээ. 1980-аад оноос хөгжиж буй болон шилжилтийн гэгдэх Болгар, Чех, Эстони, Серби, Словак, мөн Африкийн орнуудад дээрхийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэ орнуудад эмнэлгийн тусламжийн чанар, үр ашгийг сайжруулахад засаглал, санхүүжилтийг бие даасан байдалд шилжүүлэн үр ашгийг нь нэмэгдүүлж чадсан байна. Эндээс харахад, эмнэлгийн засаглал, бие даасан байдлыг сайжруулахад дан ганц эмнэлгийн Удирдах зөвлөл байгуулан, эрх мэдлийг нь өгөөд зогсохгүй, санхүүгийн болон эмнэлгийн үр ашгийг сайжруулах арга хэмжээг хамтад нь хэрэгжүүлж байж сая үр дүнд хүрнэ.

**-Тухайлбал?**

-Манайд эмнэлгийн салбарын засаглал салбарын түвшиндээ ЭМЯ, ЭМД-ын сан болон даатгалын зөвлөл, хотын ЗДТГ, дүүргийн удирдлага, МХЕГ, Сангийн яам, Төрийн албаны зөвлөл зэрэг байгууллагын хувьд хуваагдмал байдалтай байна. Ихэнх төрийн өмчийн эмнэлгүүд хүний нөөц болон төсвийн хувьд төвлөрсөн эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг. Хэдийгээр эмнэлгийн түвшинд төсөв боловсруулдаг ч төсвийн хуваарилалт болон санхүүжилт нь Сангийн яамны түвшинд эцэслэгддэг. Тэгэхээр анхны төслийн агуулга бүтнээрээ хадгалагдаж чаддаггүй.

**-Эмнэлгийн салбарын тулгамдсан асуудлын тухайд?**

-Эрүүл мэндийн салбарт 12 үндэсний хөтөлбөр, 19 стратеги, Төрөөс баримтлах таван бодлого батлагдан гарсан байдаг. Хэдийгээр энэ олон тооны баримт бичигт эмнэлгийн салбарт шинэчлэл хийх хэрэгцээ байгааг дурьдсан ч эдгээрт нэгдмэл алсын хараа дутагдалтай байна.

Өөрөөр хэлбэл 10 жилийн дараа эмнэлгийн салбар ямар байх вэ гэдэг дээр нэгдмэл зөвшилцөл бий болоогүй байх. Төрөөс эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар баримтлах бодлогоо эхлээд батлуулж байж дагалдах хуулиуд, хөтөлбөр, төслүүд хэрэгжих ёстой. ■

## MONGOLIAN ECONOMY” СЭТГҮҮЛИЙН АСУУЛТ

**Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний чанар, хүртээмжийг хэрхэн сайжруулж болох вэ?**

**Г.Мөнх-Эрдэнэ /Хөрөнгө оруулалтын шинжээч/:**

-Гэнэтийн аюулыг гэтлэх хэрэгсэл нь даатгал юм. Тэр гэнэтийн аюул хэзээ ирэх нь тодорхойгүй байдаг учир сар бүр, жил бүр даатгалд мөнгө төлөх шаардлагатай. Өвчин эмгэгийг давж гарахад эрүүл мэндийн даатгал аминд орох учиртай. Бид сар бүр эрүүл мэндийн даатгалд мөнгө төлдөг. Машинаа даатгуулсан иргэд бүх нөхөн төлбөрөө 14 хоногийн дотор бүрэн барагдуулж байна. Харин өвчин эмгэг тусвал улсын эмнэлэг яаж үйлчилдэг вэ? Гарсан зардлыг бүрэн барагдуулж эрүүл мэндийн даатгалаас төлбөрөө авч чаддаг уу? Хариултыг нь бид бүгдээрээ мэддэг шүү дээ. Хүний амь машины үнээс бага гэж үү? Үүний учир нь төр бол хамгийн муу менежер. Тиймээс эрүүл мэндийн даатгалыг чадварлаг менежментэд өгснөөр л нөхцөл байдлыг өөрчилж чадна.



**Р.Наранчимэг /НДЕГ-ын дэргэдэх Эрүүл мэндийн даатгалын газрын дарга/:**

-Эрүүл мэндийн даатгалд хамрагдсанаар иргэд зайлшгүй шаардлагатай 380 нэр төрлийн эмээр 50-80 хувийн буюу 120-180 мянган төгрөгийн хөнгөлөлт эдэлж болно. Мөн эмнэлгээс долоон төрлийн тусламж үйлчилгээ авах боломжтой. Тухайлбал, Оношилгоо, шинжилгээ хийлгэхдээ 36000 төгрөгийн хөнгөлөлт эдэлнэ. Мөн амбулаторийн буюу клиникийн эмнэлэг, аймаг дүүргийн нэгдсэн эмнэлгээс үйлчилгээ авах, уламжлалт, нөхөн сэргээх, хөнгөвчлөх үйлчилгээг хөнгөлөлтэй авах эрхтэй. Манай эрүүл мэндийн даатгалын хөрөнгийн 80 хувийг татвар төлөгч иргэд бүрдүүлж, төрөөс 20 хувийг нь даадаг. Тиймээс иргэн бүр даатгалаа цаг хугацаанд нь төлөх нь чухал. Аж ахуйн нэгж, албан байгууллагын ажилтан сарын хөдөлмөрийн хөлснийхөө дөрвөн хувийг төлдөг. Харин малчин, тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэн, ял эдэлж буй хүмүүс ▶



▶ сард 670 төгрөг, жилд 8040 төгрөг төлдөг. Улсын төсвөөс 18 хүртэлх насны хүүхэд, өндөр настан, хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч, хүүхдээ хоёр нас хүртэл өсгөж буй эцэг, эхийн даатгалын төлбөрийг даадаг. Ер нь эрүүл мэндийн даатгалын сул талыг ярихаас илүүтэй иргэдэд даатгалын энэ мэт сайн талыг нь ойлгуулах нь чухал.

#### Ч.Чулуунцэцэг /Чингэлтэй дүүргийн иргэн/:

-Улсын эмнэлэгт хийдэггүй нарийн мэргэжлийн үзлэг оношлогоонд хамрагдахад цэнхэр дэвтэр хэрэг болдоггүй. Гэтэл тэр нь өндөр үнэтэй байдаг. Дээрээс нь улсын эмнэлэгт үзүүлэх гэхээр арвангуравдугаар маяггүй бол өдөржин шөнөжин дугаарлаж байж л үзүүлэх ёстой. Гэтэл тэр дугаарлалтад бүтэн өдөр бүү хэл хэдэн өдөр дугаарлаад ч үзүүлж чадахгүй буцах тохиолдол гардаг. Тийм болохоор эрүүл мэндийн даатгалын ач тус их ч хүн бүрт хүрч чадахгүй байна уу даа гэж бодогдсон.



#### Ч.Идэрболд /Хан-Уул дүүргийн иргэн/:

-Би эрүүл мэндийн даатгалаа хувиараа төлдөг. Учир нь, өвчин гэдэг хэлж биш хийсч ирдэг шүү дээ. Тэр үед магадгүй чиний хэтэвчинд мөнгө байхгүй бол эрүүл мэндээрээ хохироод үлдэхээс өөр аргагүй. Тиймээс эрүүл мэндийн даатгалыг хувиараа төлөх нь гэнэтийн осол эндэгдэлд орсон тохиолдолд улсын эмнэлэгт үнэ төлбөргүй болон хөнгөлөлттэй үзүүлэх эрх бүрддэг. Мөн эрүүл мэндийн даатгалын хураамж бага бөгөөд жил дотроо өнгөрсөн хэдэн сарынх ч байсан төлж болдог нь бидэн шиг сайн дураараа даатгалаа төлдөг иргэдийн ажлыг их хөнгөвчилж байгаа. Гэхдээ хураамжийн хэмжээ бага байдаг болоод ч тэр үү үйлчилгээний чанар, ажилчдын соёл тааруу байдаг. Ер нь олон нийтийн дийлэнх нь эрүүл мэндийн даатгалыг төлдөг ч тэр нь ёс төдий зүйл болчихсон шүү дээ. Дундаас дээш орлоготой хүмүүс нийгмийн даатгалаа төлдөг ч хувийн эмнэлгээр үйлчлүүлэх хүсэл сонирхолтой байдаг нь үүнтэй холбоотой болов уу.



#### Б.Нямдаваа /АШУУИС-ийн эмчилгээний магистрант/:

-Улсын эмнэлэгт дадлага хийж байхад хүмүүсийн ихэнх нь эрүүл мэндийн даатгалын дэвтрээ ашиглаж мэддэггүй. Зарим нь бүр даатгалын дэвтрээ орхиод

ирэх нь элбэг. Эмч болон сувилагч нар тухайн өвчтөнд даатгалын учрыг нь тайлбарлаад өгөхөөр "өө тийм үү" гээд дэвтрээ авчирхаар буцаад явдаг. Уг нь улсын эмнэлэг нь хүрэлцээтэй, нарийн мэргэжлийн тоног төхөөрөмж нь хувийн эмнэлэг шиг сайн байдаг бол цэнхэр дэвтэр шиг хэрэгтэй зүйл байхгүй.

Гэхдээ улсын эмнэлгийн тоног төхөөрөмж муу, нийтлэг хийдэг үзлэг шинжилгээний дараалал их байдаг. Тухайлбал, биохимийн шинжилгээ өгөхөд дугаарлалт ихтэй байдаг. Мөн дотор болон чих, хамар, хоолойн үзлэг хамгийн их дараалалтай. Хэрвээ болдог бол эдгээр ачаалал ихтэй үзлэг шинжилгээг улсын болон хувийн эмнэлгийн алинаар нь ч үзүүлсэн даатгалын дэвтрээр үйлчилдэг болчихвол эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний хүртээмж сайжрах болов уу.

#### Э.Бүжинлхам /"Интермед" эмнэлэгт сувилагч/:

-Эрүүл мэндийн даатгалын давуу талын хувьд улсын эмнэлэгт үнэ төлбөргүй үзүүлэх, зөвшөөрөл эрх олгосон зарим эмийн сангуудаар хөнгөлөлттэй үйлчлүүлэх давуу талтай. Тухайлбал, та эрүүл мэндийн даатгалд хамрагдсанаар долоон төрлийн үйлчилгээг авч нэг сая гаруй төгрөгийн хөнгөлөлт эдлэх эрхтэй болно. Үүний нэг нь эмийн сангаар хөнгөлөлттэй үйлчлүүлэх. Үүний хөнгөлөлттэй эмэнд даралт бууруулах, зарим тохиолдолд уналт, таталт, багтраа, амьсгалын замын өвчнөөс сэргийлэх болон бүх төрлийн амин дэм багтаж байгаа. Хөнгөлөлт эдлэхдээ өрхийн эсвэл сумын эмчийн бичсэн жорыг эрүүл мэндийн даатгалын дэвтрийн хамт авчирч хямдрал эдлэх боломжтой юм. Энэ нь орлого багатай иргэдийн хувьд төрөөс үзүүлж буй том дэмжлэг. Гэхдээ үүнийг иргэд тэр бүр мэддэггүй юм шиг санагддаг. Мэдэхгүй болохоор тухайн хөнгөлөлтийг иргэд эдэлж чаддаггүй. Мөн хувийн эмнэлгүүдээр үйлчлүүлэх гэхээр эрүүл мэндийн даатгалыг ашиг шимийг хүртэж чаддаггүй. Тухайлбал, манай "Интермед" эмнэлэг Монголд урд өмнө нь хийж байгаагүй дөрвөн төрлийн хагалгаа, 10 орчим төрлийн шинжилгээг хийдэг. Гэхдээ эдгээр үзлэг, шинжилгээнд хамрагдахад эрүүл мэндийн даатгал хэрэг болдоггүй. ■



## ДААТГАЛ

# ДААТГАЛЫН САН ИХ БОЛОХ ТУСАМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР САЙЖИРДАГ

## Э.ЗОРИГТ

Эрүүл мэндийн даатгал тойрсон асуудлын талаар олонтаа ярьдаг. Тэгвэл энэ удаа тэдгээр асуудлаас хэрхэн гарах талаар Амьдралын даатгалын “Нэйшнл Лайф Даатгал” компанийн гүйцэтгэх захирал Г.Монголхүүтэй ярилцсан юм. “Нэйшнл Лайф Даатгал” ХХК нь 2007 оноос үйл ажиллагаагаа явуулж байгаа хүний амь нас, эрүүл мэндийн даатгалаар мэргэшсэн анхдагч компани юм.

**-Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо манайд үр дүнгээ өгөхгүй буруу яваад буйн гол шалтгааныг та даатгалын салбарт ажиллагдийн хувьд хэрхэн хардаг вэ?**

-Өнөөгийн эрүүл мэндийн даатгалд хэд хэдэн асуудал бий. Эхнийх нь хүн бүр тодорхой хураамжийг эрүүл мэндийн даатгалд төлдөг. Хуулиараа хэрвээ та ажил хийдэг бол нийт авч байгаа цалингийнхаа хоёр, ажил олгогчийн зүгээс мөн хоёр хувийг буюу нийтдээ дөрвөн хувийг төлж байж нийгмийн даатгалын үйлчилгээ авах эрхтэй болно. Энэ дөрвөн хувь бол эрүүл мэндийн даатгалын босго гэсэн үг. Уг босго хувиар тооцогддог учраас хэрвээ та их цалин авдаг бол эрүүл мэндийн даатгалд төлөх мөнгөн дүн өснө гэсэн үг. Тухайлбал, та хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ буюу 192



мянган төгрөгийн цалин авдаг байлаа гэхэд сар бүр ойролцоогоор найман мянган төгрөг төлнө. Хэрвээ таны цалин өсвөл тэр хэрээр сард төлөх мөнгөн дүн нэмэгдэнэ. Гэтэл зарим нэг хүмүүсийн хувьд найман мянган төгрөг нэг сарын биш жилд төлөх мөнгө байдаг. Тэр нь хүүхэд, хөгшид, ажилгүй иргэд гээд төрөөс анхаарах ёстой иргэд юм. Тэгвэл ажилтай иргэдэд яагаад ийм өндөр босго тогтоогоод байгаа юм бэ. Ажилгүй хүнд ямар шалтгаанаар бага босго тавиад байна вэ. Энэ нь төсөвтэй холбоотой байж болох. Нөгөө талаасаа нийгмийн даатгал халамжийн бодлого хоорондоо холилдоод байгаатай холбоотой. Уг нь халамжийн бодлого, нийгмийн даатгал хоёр тусдаа байх ёстой. Гэтэл өнөөдрийн байдлаар

эрүүл мэндийн даатгалын тогтолцоо нь хямд зардлаар төрийн халамжийн бодлогыг шийдэх гарц болчихоод байна. Учир нь, төрөөс настай хүн, хүүхэд гээд нийгмийн халамж хэрэгтэй тэр хэсгийн эрүүл мэндийн даатгалын мөнгө гэж жилийн найман мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлдэг. Гэтэл тэдгээр хүмүүс жилд 8000 төгрөг төлөөд л өнөөдрийн авч байгаа хэмжээний эрүүл мэндийн үйлчилгээ авч чадах уу гэвэл үгүй. Тэгвэл тэр зөрүүг хэн төлж байна вэ. Нөгөө л ажил орлоготой иргэдийн цалингаасаа өгч байгаа дөрвөн хувиар нөхдөг. Үүнийгээ эв санааны нэгдэл гээд байгаа. Гэтэл эв санааны нэгдлийн талаарх нийтлэг тодорхойлолт нь “Тэгш бус эрсдэлд тэгш хэмжээний шимтгэл ногдуулахыг ▶



▶ хэлнэ” гэсэн байдаг. Товчхондоо ажил орлоготой иргэдийн нуруун дээр илүү ачаа үрүүлээд байна гэсэн үг.

**-Өнөөдөр эрүүл мэндийн даатгал тойрсон олон асуудал байдаг. Тэр нь ажил хийдэг иргэд илүү мөнгө төлдөг мөртлөө эрүүл мэндийн даатгалын дэвтрээрээ эмчилгээ үйлчилгээ бараг авдаггүй. Гэтэл нөгөө бага төлдөг хэсэг нь их авдаг. Мөн таны хэлснээр ажилтай хэсгийн төлдөг хураамж, нөхөөсөнд яваад байна. Тэгвэл энэ тогтолцоог хэрхэн өөрчлөх вэ?**

**Хамгийн энгийн арга бол төр хариуцах ёстой иргэдийн эрүүл мэндийн даатгалын санд сар бүр төлдөг мөнгийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний цалинтай хүний төлдөг хэмжээнд аваачих хэрэгтэй. Энэ бол шударга тогтолцоо.**

-Хамгийн энгийн арга бол төр хариуцах ёстой иргэдийн эрүүл мэндийн даатгалын санд сар бүр төлдөг мөнгийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний цалинтай хүний төлдөг хэмжээнд аваачих хэрэгтэй. Энэ бол шударга тогтолцоо. Даатгалын үйлчилгээ сангийн хэмжээтэй шууд холбоотой байдаг. Хэрвээ энэ босгыг жилд 8000 биш сар бүр ийм хэмжээний төгрөг төлдөг болчихвол сангийн хэмжээ ихэснэ. Сангийн хэмжээ ихсэх тусам эмчилгээ үйлчилгээний чанар сайжирна. Өнөөдрийн байдлаар бид 1,112,000 төгрөгийн хамгаалалт авдаг. Энэ бол бага мөнгө. Гэхдээ авч байгаа үйлчилгээний цар хүрээ нь бол маш өргөн. Эрүүл мэндийн даатгалын сангийн үйлчилгээний цар хүрээ өргөжих тусам нэг хүнд ногдох

хүртээмж багасдаг. Үүнийг яаж шийдэж болох вэ гэвэл нэг хүнээс авч байгаа шимтгэлийн хэмжээг нэмэгдүүлж болно.

**-Эрүүл мэндийн даатгалын салбарт хувийн хэвшлийнхэн идэвхтэй оролцож өрсөлдөөн бий болгож болохгүй юу?**

-Хувийн даатгалын салбарыг эрүүл мэндийн даатгал руу оруулах хэрэгтэй юу гэвэл хэрэгтэй. Гэхдээ хувийн хэвшлийг өрсөлдөгч гэдэг утгаар нь биш уялдаа холбоотой хамтран ажиллах гэдэг утгаар нь хүлээж авах учиртай юм. Гэтэл өнөөдөр хувийн даатгал гэхээр л нэг л их ашиг харсан нөхдүүд гэж ойлгоод байдаг. Уг нь тийм биш. Хувийн сектор гэдэг хамгийн эрүүл, илүү үр ашигтай тогтолцоог гаргаж ирдэг шүү дээ. Өнөөдөр хүнд өвчин тухайлбал, хорт хавдар туссан хүн оношлуулж, эмчлүүлэхийн тулд өөрийн болон ах, дүү хамаатан садангийнхаа мөнгө төгрөгийг шавхаад, байр саваа худалдаж, зээлэнд тавьж байж шаардлагатай мөнгөө цуглуулаад гадагшаа эмчилгээнд явж байна. Тэгвэл мөнгөгүй, ах дүү муутай хүн бол өвдөөд л хэвтэхээс аргагүй байдаг. Энэ бол маш эмгэнэлтэй асуудал. Тэгвэл яг энэ хэсэгт чиглэсэн үйлчилгээг хувийн даатгалын компаниуд бий болгох нөхцөлийг нь төрөөс гаргаад өгөх хэрэгтэй байна. Учир нь, төр энэ хэсэгт хүрч чадахгүй байна шүү дээ. Тэр хүрч чадахгүй байгаа хэсэгтээ хувийн хэвшилтэйгээ хамтраад очих ёстой. Төр хувийн хэвшлийн түншлэлийн ийм жишээ олон улсад цөөнгүй бий. Түншилдэггүй юм аа гэхэд татварын болон бусад төрийн бодлогоор дэмжээд хувийн хэвшлийг энэ салбарт оруулах боломжийг нь бүрдүүлээд, хөшүүргийг бий болгочихвол тэд ороод л ирнэ.

**-Ямар хөшүүрэг байж болох вэ?**

-Барууны оронд бүх үйлчилгээг эрүүл мэндийн даатгалаараа авч болдог.

Ханиад хүрсэн ч эмээ аваад уучихдаг. Хорт хавдар туссан ч хагалгаагаа очоод хийлгэчихдэг. Гэтэл манайд тийм биш. Ийм болгохын тулд төр, хувийн хэвшил хоёр үйл ажиллагааны хувьд мөргөлдөхгүйгээр хамтран ажиллах хэрэгтэй байна. Тухайлбал, ханиад, хорт хавдар хоёрын аль нь илүү түгээмэл өвчин бэ. Мэдээж ханиад. Тэгвэл төр хэсгийн үйлчилгээг төр даадгаараа даагаад хорт хавдар туссан иргэдэд үзүүлэх үйлчилгээг хувийн хэвшилд даатгачих ч юм уу. Гэхдээ хувийн даатгалын санг оруулахын тулд хөшүүрэг хэрэгтэй. Үүний хамгийн энгийн арга нь эрүүл мэндийн даатгалын босгыг ижил түвшинд аваачих юм. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр хүн бүр эрүүл мэндийн даатгалд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний цалингийн дөрвөн хувьтай тэнцэх хэмжээний мөнгө буюу 8000 төгрөгийг сар бүр төлдөг болчих хэрэгтэй. Хэрвээ сард 500 мянган төгрөгийн цалин авдаг, түүнийхээ дөрвөн хувийг буюу 20 мянган төгрөг төлдөг байсан бол нөгөө яриад байгаа босго сарын 8000 төгрөг болно. Ингэвэл чамд цаана нь 12 мянган төгрөг үлдэнэ. Тэр үлдсэн мөнгөөрөө тухайн ажил хийдэг иргэн хувийн даатгалын салбарт ирээдүйд учирч болзошгүй хүнд өвчний эрсдэлээ яагаад даатгуулж болохгүй гэж. Ингэсэн тохиолдолд чиний даатгалын үйлчилгээ өндөр болно гэсэн үг. Монголын ирээдүйг бүтээлцэж байгаа ажилтай иргэн хүнд өвчний улмаас жагсаалтаас гарах ёсгүй. Гэтэл өнөөдрийн нөхцөл байдлаас харвал хэтэвч л хоосон бол хүнд өвчин тусаад хувь заяатайгаа эвлэрэхээс өөр арга алга. Хэрвээ зөв тогтолцоог бий болгочихвол ажил хөдөлмөр эрхэлж байгаа иргэдээ хамгаалж чадна шүү дээ. Ажил хийдэггүй хэсэг нь ажил хийж, эрүүл мэндийн даатгалаа төлөхийг хичээнэ. Ингээд ирэхээр нийгэм эрүүлжээд эхэлдэг. ■

## АСУУДАЛ

## НӨАТ-ЫН ЭРГЭН ТОЙРОНД

## Б.БАЯРТГОТХ

Засгийн газраас НӨАТ-ын хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн мэдүүлээд багагүй хугацаа өнгөрч байна. Хаврын чуулганаар уг хуулийн төслийг бүрэн хэлэлцэж амжаагүй тул Намрын чуулганы хэлэлцэх асуудалд багтаасан. Шинэчлэл одоогийн эрчээрээ явбал сунжирсаар ирэх онтой ч золгож мэдэх нь. УИХ-ын гишүүн, Сангийн сайд асан Ч.Улаан “НӨАТ-ын хуулийн шинэчилсэн найруулгын зорилго нь бизнест ээлтэй орчин бүрдүүлэх, татварын энгийн ойлгомжтой тэгш шударга байх зарчмыг хангах. Түүнчлэн эдийн засгийн өсөлтийг дэмжих. Мөн олон улсын жишигт нийцүүлсэн тогтвортой орчинг бий болгоход оршиж байна” хэмээн тайлбарласан.

Монгол Улсад 1998 оноос хэрэгжиж эхэлсэн НӨАТ-ын хуульд өмнөх 16 жилийн хугацаанд 30 гаруй удаа өөрчлөлт орсон байдаг. Ингэснээр хөнгөлөлт, чөлөөлөлтийг хэт хавтгайруулсан гэх. Энэ нь татварын тогтолцоог гажуудуулж байгааг Хувийн хэвшлийг дэмжих үндэсний зөвлөлөөс мэдэгдсэн удаатай. Харин үүнийг Сангийн яамнаас эрс үгүйсгэсэн. Татварын өнөөгийн тогтолцоог харвал хөнгөлөлт, чөлөөлөлт байнга нэмэгдсээр иржээ. Үүнийг дагаад татварын маргаан жил ирэх тусам өссөн байна.

Сүүлийн гурван жилд УИХ-аар НӨАТ-ын хуулийн төслийг хоёр удаа өргөн барьсан бөгөөд алийг нь ч батлаагүй. Татварын хуулийн багц шинэчлэлийн хүрээнд НӨАТ гурав дахь удаагаар орж ирээд байгаа нь энэ. Гэхдээ энэ удаад сөрөг хүчин бус Засгийн газар оруулж ирсэн. Тиймээс хуулийн төсөл

УИХ-ын гишүүдийн дэмжлэг авах нь тодорхой гэсэн “мессеж”-ийг өгч байгаа юм. НӨАТ-ыг жижиг улс оронд нэн тохирсон, улсын төсөв бүрдүүлэхэд хамгийн үр ашигтай татвар гэдэг. Гэвч нийгэмд хамгийн их гомдол, маргаан дагуулдаг татвар. Уг хуулийг зөрчсөн, гэмт хэрэгт холбогдсон аж ахуйн нэгж аль хэдийнэ 2000 давсан гэх албан бус тоо ч бий.

Засгийн газраас бизнесийг дэмжсэн татварын хоёр дахь шатны шинэчлэл НӨАТ-т нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлаар эхэлсэн. Гэвч Худалдааны татвар гэсэн шинэ хувилбарыг босгоод ирэв. Гэхдээ манай улсын хувьд худалдааны татвараас илүүтэй НӨАТ оновчтой

давхардал үүсгэдэг аж. Экспортод хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлдэг. Гэхдээ далд эдийн засгийг хянах боломжгүй. Мөн татвар төлөхөөс зайлсхийх боломжтой. Энэ нь худалдааны татвараас татгалзах үндсэн шалтгаан болсон аж. Татварын хуулийг сайжруулах, өөрчлөгдөж байгаа нөхцөл байдалтай уялдуулах нь энэ удаагийн шинэчлэлийн гол нугалах ажил гэж хэлж болохоор. Гэхдээ татварын шинэчлэл гэхээр улсын хэмжээнд хэрэгжиж буй 23 нэр төрлийн татварт өөрчлөлт орох нь гэж шууд ойлгож болохгүй.

Манай улсын хувьд 2000 оноос хойшхи хугацаанд татварын орлого 23 дахин, улсын төсөв бараг 10 дахин ▶

Монгол Улсад 1998 оноос хэрэгжиж эхэлсэн НӨАТ-ын хуульд өмнөх 16 жилийн хугацаанд 30 гаруй удаа өөрчлөлт орсон байдаг.

гэж УИХ-ын гишүүн С.Баярцогт дүгнэсэн. Худалдааны татварын хувьд манайх өмнө нь хэрэглэж байсан туршлагатай. Энэхүү татварыг үйлдвэрлэл, импорт, бөөний худалдааны түвшинд хэрэгжүүлж байсан. Өмнөх шатанд төлсөн татварын хасалт хийдэггүй тул олон дахин татвар ногдуулж татварын



► нэмэгдсэн байна. ДНБ-д эзлэх төсвийн зардал 40 гаруй хувь болж өссөн. Мөн эдийн засаг 14 дахин тэлжээ. Энэ хэрээр татварын зохицуулалт, түүний дагаж мөрдөх журамд ч шинэ зохицуулалт шаардагдах болов. “Делойтт онч аудит” компанийн захирал Д.Ончинсүрэн “НӨАТ нь эцсийн дүндээ аливаа улс орны иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг нэг тайлан баланст оруулах, сүүдрийн эдийн засгийг багасгах, татварын мөнгөний урсгалыг төр өөрийн хяналтад байлгаж, хувь хүн, аж ахуйн нэгж байгууллагыг санхүүгийн цэгцтэй тогтолцоонд оруулах механизм юм” гэж тодорхойлсон байдаг.

НӨАТ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хамгийн их анхаарал татаж байгаа зүйл нь 50 саяын босго. Шинэ хуулиар НӨАТ-ын босгыг 50 сая төгрөг болгож өсгөснөөр аж ахуйн нэгжүүд жижгэрэх, хуваагдах замаар татвараас бултах санаархлыг нэмэгдүүлэх сул талтай гэсэн байр суурь хувийн хэвшлийнхэд бий. НӨАТ-ын тухай хуульд өөрчлөлт оруулснаар НӨАТ төлөгч жижиг, дунд бизнес эрхлэгчдийн 50 орчим хувь нь НӨАТ-ын тайлан гаргах, бүртгэл хөтлөх, падаан цуглуулах үйл ажиллагаанаас

“чөлөөлөгдөх” юм. Өөрөөр хэлбэл, цаасан татварын системээс цахим татварт шилжих аж.

НӨАТ-ыг төсөв бүрдүүлэх гол хэрэгсэл болгосон нь уг хуулийн мөн чанар, үзэл баримтлалтай зөрчилдөж буйг СЭЗДС-ийн ахлах багш Ч.Өнөржаргал хэлсэн юм. Мөн тэрбээр “НӨАТ-ын хуулийн нэг дутагдалтай тал нь хөнгөлөлт, чөлөөлөлт хэтэрхий их. Хэрвээ үйлдвэрлэгчдийг дэмжих гэж байгаа бол шууд бус татвараар биш, орлогын татвараар дэмжих ёстой” гэв. Үүнтэй ч УИХ-ын гишүүн Ц.Оюунбаатар санал нэгтэй байгаа. Тэрбээр “Бүгдээрээ НӨАТ төлөгч болох нь зөв. Цаашдаа татварыг нийтээрээ төлдөг байхын тулд дэмий хөнгөлөлт, чөлөөлөлтийг багасгах ёстой. Бодлогын шинж чанартай ганц хоёр зүйлээ чөлөөлөөд, бусдыг нь эрс багасгах хэрэгтэй” гэсэн.

Төсвийн орлогын 85 хувь, татварын нийт орлогын 34 хувийг тус тус бүрдүүлж буй аж ахуйн нэгжүүд НӨАТ төлөгчид. Тэд нийт аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн дөнгөж 1.25 хувийг эзэлж байна. Шинэ хуулиар НӨАТ төлөгч аж ахуйн нэгжүүдийн татварын ачаалал, дарамт улам нэмэгдэхээр байгаа талаар МҮХАТ-

ын Нэгдсэн бодлого төлөвлөлт, зохицуулалтын газрын дарга Ч.Нэргүй нэг бус удаа хэлж буй. Танхимын зүгээс өлгийтэй нялхаас эхлээд өтөл хөгшид хүртэл бүгд энэ татварыг төлж байна хэмээсэн. НӨАТ-ын дарамт эцсийн хэрэглэгч буюу татвар төлөгч иргэдэд хүндээр тусч ирсэн гэж зарим судлаач шүүмжилдэг.

НӨАТ-ын үндсэн зорилго нь далд эдийн засгийг ил болгох. Гэтэл өнөөдөр тус хууль төсвийн орлого бүрдүүлэхэд чиглэж, төсвийн 20 орчим хувийг хангаж байна. Нийт татварын орлогод НӨАТ-ын эзлэх хувь 2000 онд 19 хувь байсан бол өнгөрсөн оны байдлаар 32 хувь болж, даруй 13 хувиар өссөн дүнтэй гарчээ. Энэ нь НӨАТ төсөвт онцгой үүрэг гүйцэтгэх болсныг харуулж байна. Хөгжиж буй орны хувьд НӨАТ-ын хувийг тав болгон бууруулах нь оновчтой гэж бизнес эрхлэгчдийн дийлэнх нь үздэг. “Дөрвөн 10”-ын тогтолцооноос “Дөрвөн 5”-ын тогтолцоонд шилжих нь оновчтой гэсэн байр суурь ч нэлээд түгээмэл яваа. Татварын хоёр дахь шатны шинэчлэлийн тэргүүн эгнээнд яваа НӨАТ-ын эргэн тойронд асуудал ийм байна. Шинэчлэл зогсоогүй, үргэлжилсээр. ■





## ТАТВАР

## ЦАГ АЛДСААР, ОРЛОГО ТАСАРСААР

## Б.ҮҮРИЙНТУЯА

Урьдчилгаа төлбөрөө уралдаж төлөөд, Монголын нүүрсийг өрсөлдөж авдаг байсан үе ард хоцорч монголчууд “Манайхаас нүүрс аваач ээ” гээд гуйх нь холгүй болж. Цагийн сайханд 10 гаруй компани нүүрс экспортолж байсан бол өдгөө 3-4 нь л жигд бус, аргацаах төдий үйл ажиллагаагаа үргэлжлүүлж байгаа нь даанч харамсалтай.

Өсмөөр байна, хөгжмөөр байна. Уул уурхайгаа дэмжмээр байна гэсээр тэргүүлэгч гэгдэх нүүрсний салбар өнөөдөр төрийн удирдлагуудын туршилтын туулай болоод байна. Ашигт малтмалын тухай хууль, Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр хураах аргачлал, жишиг үнэ тогтоох журам гээд туршилт үргэлж нүүрсний салбараас эхэлдэг бол горьг нь ч мөн нүүрсний салбар түрүүлж амсдаг. Алдаагаа ухаарсан уу гэлтэй

Засгийн газар өнгөрсөн дөрөвдүгээр сард нүүрс экспортлогчдыг дэмжих үүднээс борлуулалтын гэрээний дүнгээс татвар тогтоохоор шийдвэрлэсэн. Ингэснээр тус салбарт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж хэт өндөр жишиг үнээр татвараа төлөх бус Монголын зах зээл дээрх бодит үнээр татвараа тооцуулах таатай нөхцөл бүрдэх байв. Гэвч хэрэгжилт үгүй хуулийн заалт цаасан дээр л баталгаажиж байна. ▶

▶ Монгол Улсын уул уурхайн салбарын үйл ажиллагааг зохицуулах 20 гаруй хууль байдаг бол тус салбарт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүд 18 орчим төрлийн татвар, төлбөр, хураамжийг улсын болон орон нутгийн төсөвт оруулдаг. Эдгээрээс Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр салбарынхны толгойны өвчин болдог аж. Монголын эдийн засгийн хөгжлийг тодорхойлж яваа уул уурхайн салбарын татварын асуудлыг өнөөгийн татварын шинэчлэлд тусгаагүй, орхигдууллаа гэх хэсэг байхад “онцгой” салбараа бусадтай хольж хутгах нь өрөөсгөл, иймд эрс тэс орчин шаарддаг, гадаад дотоод худалдааны цар хүрээ нь өөр зах зээлийг тусгайлсан бодлогоор дэмжих нь зүйтэй гэх хэсэг байна. “Монгол нүүрс ассоциаци”-ийн захирал Т.Наран “Бүгдийг нэг саванд чихэх шаардлагагүй. Харин ерөнхий орчноо сайжруулчихаад уул уурхайн татварын орчинг тусгайлан анхаарч ажиллах хэрэгтэй” гэв.

Монголын гэлтгүй дэлхийн уул уурхайн салбарын тэсрэлтийн үе тохиосон 2009, 2010, 2011, 2012 онуудад манай улс экспортынхоо 90 гаруй хувийг нүүрсний борлуулалтад даатгаж явсан. Үргэлж сайхнаараа байх мэт төсөөлж хамтаръя, санхүүжүүлэе гэсэн хөрөнгө оруулагчдад төрийн зүгээс хэтэрхий хатуу хандаж, “хамраа сөхөж” явсаар энэ оны байдлаар экспортын зорилтоо ч биелүүлж чадахгүйд хүрэв. Орлого хөөж, ашиг олох гэсэн өнгөц сэтгэлгээ нүүрсний салбарын ирээдүйг үгүй хийх нь гэдгийг нүүрс экспортлогчид анхааруулдаг. Т.Нарангийн хэлж буйгаар, төрийн болгоомжгүй хандлага, шинэ зах зээлийг бүрэн ойлгоогүйн улмаас үүдсэн нөхцөл байдлыг залгаад гол нийлүүлэгч болох Хятадын эдийн засгийн өсөлт саарсан нь манай улсын эрдсийн бүтээгдэхүүний салбарт уналт “уриалсан”. Түүнчлэн эрэлтийг дагаад нийлүүлэлт хийх хүсэлтэй бусад орны өрсөлдөөн чангарсан нь үйлдвэрлэлийн өртөг өндөртэй манай улсын хувьд зах зээлийн том тоглогч байх боломжийг хааж байгаа юм.

Уул уурхайн зах зээл уналт, сэргэлтийн мөчлөгтэй. Уналтын мөчлөг тохиогоод буй өнөө үед салбараа алдахгүй, аргацаах хэрэгтэй байна. Т.Наран

“Өрсөлдөх чадварт хамгийн их нөлөөлдөг хүчин зүйл бол дэд бүтэц, тээвэрлэлт. Австралиас Хятадын урд эргийн боомтуудад бүтээгдэхүүн хүргэхэд нэг тонн нүүрс 12-15 ам.доллар байхад Тавантолгойгоос Гашуунсухайтын хил хүртэл тээвэрлэлт хийхэд 20-25 ам.долларын зардал гарч байна. Манайх Хятадын далайн эргийн боомтуудад нүүрсээ хүргэдэг байх хэрэгтэй. Ингэснээр тодорхой хэмжээний зах зээлтэй байна. Манайхан Хятадын зах зээлийг хангана гэж улайрах хэрэггүй. Чадах ч үгүй. Бас шаардлага байхгүй” гэсэн юм.

### Орлого хөөж, ашиг олох гэсэн өнгөц сэтгэлгээ нүүрсний салбарын ирээдүйг үгүй хийх нь гэдгийг нүүрс экспортлогчид анхааруулдаг.

Уул уурхайг улсынхаа хөгжлийн түлхүүр болгосон орнуудын татварын орчин маш уян хатан, салбараа дэмжсэн байдгийг судлаачид тайлбарладаг. Хамгийн ойрын жишээ гэвэл Хятад. Хөршийн Засгийн газар зах зээлийн өөрчлөлттэй татварын бодлогоо уяж, дотоод зах зээлээ дэмждэг байна. Үүний илрэл нь өнгөрсөн сарын 15-наас хэрэгжиж эхэлсэн эрчим хүчний салбар дахь татварын шинэчлэл билээ. Хятадын Засгийн газраас хэрэгжүүлж эхэлсэн энэхүү шинэчлэлийг дотоодын нүүрс үйлдвэрлэгчдээ дэмжиж уналтын үеийг хохирол багатай даван туулах, зах зээл сэргэхэд ашигтай ажиллана гэх урьдчилсан нөхцөл бүрдүүлэх зорилго агуулж байгаа хэмээн олон улсын эдийн засагч, судлаачид үзэж буй. Түүнчлэн импортын хямд нүүрсэд зах зээлээ алдаж байсан “China Shenhua Energy Company”, “China Coal” зэрэг томоохон компаниудынхаа үйл ажиллагааг доголдуулахгүй гэсэн далд санаа бий гэдгийг ч дэлхийн эдийн засагчид онцолж байна. Тэгвэл импортын нүүрсний нэг тонн тутамд 3-6 хувийн татвар (10-20 юань)

ногдуулахаар шийдвэрлэсэн Хятадын Засгийн газрын зүгээс уг шинэчлэлийг байгаль, экологио хамгаалах, нүүрсний чанартай хэрэглээ бий болгох түр хугацааны арга хэмжээ хэмээн тайлбарлаж байгаа юм. Ямартаа ч шинэчлэлийн дүнд “Shenhua” компанийн ашиг найман хувиар өсөхөөр байгаа бол “China Coal”-ийн ашиг 16 хүртэлх хувиар нэмэгдэх аж. Бусад нүүрсний компанийн ашиг дунджаар есөн хувьтай байна гэх таамаг гараад буй. Ийн бодлогоор дэмжих нь төрийн оролцоо гээчийн илрэл бөгөөд төр нь компани байгуулаад нүүрсээ ухна гэж зүтгэх нь өрөөсгөл аж.

Албан мэдээллээр Монгол улсын гадаад валютын нөөц 1.3 тэрбум ам.доллар байна гэх ч Төвбанкны гадаад өрийг хасвал манай улсын үндэсний аюулгүй байдал ердөө 0.5 тэрбум ам.доллараар хэмжигдэж байгааг анхаарууштай. Гэтэл валютын нөөцийн гол бүрдүүлэгч гэж болох нүүрсний салбарт татвар хураах аргачлал тодорхойгүй, ямар журам мөрдөхөө мэдэхээ байчихсан байх жишээтэй. Тухайлбал, нүүрсний оргил үе байсан 2012 онд тогтоосон жишиг үнэ өнөөдрийг хүртэл ямар ч өөрчлөлт, тохируулагагүй мөрдөгдсөөр байна. Түүнчлэн гэрээний дүнгээр татвар тооцох Засгийн газрын тогтоолын хэрэгжилт тэг хувьтай, наадмын өмнөхөн өөрчлөлт оруулсан гээд цэгцрээгүй асуудал олон. Дэндүү оройтож баталсан гэрээний үнийн дүнгээс АМНАТ тооцох журам хэрэгжилгүй цаг алдсаар байгааг Т.Наран халаглан ярьж байв.

Гэрээний үнээр татвар тооцохгүй байх хэд хэдэн шалтгаан байдгийг төрийн холбогдох байгууллагуудын зүгээс учирладаг. Сангийн яам, Татварын ерөнхий газар тэргүүтэй байгууллагууд стандарт, ангилал ярьж багагүй хугацаа “хожиж” чадсан. Үүнтэй холбоотойгоор СЭЗДС-ийн Нягтлан бодох бүртгэлийн тэнхмийн ахлах багш Ч.Өнөржаргал “Манай улсын татварын хэмжээ төлж дийлэхээргүй өндөр биш. Харин механизм дээр алдаа гардаг” гэлээ. Тэрбээр “Экспортод бүтээгдэхүүн гаргахад эцсийн бүтээгдэхүүн мөн, биш эсвэл агууламж хэдэн хувь бэ гээд Гаалийн төв лабораторийн ▶

► дүгнэлт гардаг. Гэтэл худалдан авагч дээр очоод дүгнэлт зөрөх тохиолдол байдаг. Ингэхээр татварын хувьд зөрүү гарах магадлал бий” хэмээсэн. Хүсээд байгааг нь хүлээлгэн өгсөн ч нуудаг, хаадаг, орлогоо худал мэдүүлдэг гэх шалтгаанаар Засгийнхаа журмыг эс мөрдөх төрийн байгууллагууд бий. Энэ нь чухал салбарын хөгжилд чөдөр болсоор байгааг нүүрс “зөөдөг” хэд нь хэлдэг. “Тухайлбал, нүүрс экспортолж буй 12 компани байхад гурав нь л мэдээллээ ирүүлээ. Иймд татвар ногдуулах дүнг тооцож болохгүй байна” гэсэн тайлбар олонтаа дуулддаг. “Борлуулалтын гэрээний үнээс татвар тооцох Засгийн газрын шинэ тогтоолд журмын дагуу материалаа ирүүлсэн байгууллагуудад гэрээний дүнгээр тооцсон татвар ногдуулна, ирүүлээгүйд нь жишиг үнээр АМНАТ бодно гээд тодорхой заачихсан” хэмээн Т.Наран тайлбарласан юм. Энэ тал дээр Ч.Өнөржаргал “Төрөөс Татварын ерөнхий газарт төлөвлөгөө өгдөг. Төлөвлөгөөний биелэлтээр ажлыг нь дүгнэдэг. Ингэхдээ хуулийн хэрэгжилт хэр байгааг төдийлэн хардаггүй. Ажлаа дүгнүүлэх гол шалгуур нь төлөвлөгөөний биелэлт учраас ямар нэг аргаар сайн дүн авах шаардлагатай болно. Энэ байдал хуулийг зөрүүтэй тайлбарлах, мушиган гуйвуулах, хуулиас гадуурх журам батлах зэрэг доголдлыг үүсгэж байгаа юм. Түүнээс гадна агентлаг хоорондын уялдаа холбоо гэж алга” гэдгийг нуусангүй. Тэгвэл борлуулаагүй үнээс татвар (жишиг үнээс) төлж буй талаар Ч.Өнөржаргал “Жишиг үнэ тогтоох шаардлагатай. Борлуулсан үнээр АМНАТ тооцоход зах зээлийн үнийн хэлбэлзлээс улбаалан маргаантай асуудал дахин дэгдэнэ. Манайд нягтлан бодох бүртгэл сайн хөгжөөгүй. Нуудаг, бууруулдаг, хуурдаг зуршлаасаа салж чадаагүй байна. Иймд борлуулалтын үнэлгээг зөв тогтоох хүндрэлтэй” гэсэн юм.

Одоогоор Засгийн газрын тогтоолд оруулсан өөрчлөлтийн дагуу нүүрс олборлогч бүх компаниас жишиг үнээр тоохон татвараа авахаар хэлэлцэж байгаа аж. Тэгээд оны эцсээр, гэрээний үнэ бодит эсэх нь нотлогдвол, зөрүү олгох бололтой. Энэхүү өөрчлөлтөд нүүрс экспортлогчдоос бодит санал аваагүй юм байна.

Засгийн газрын гол зорилго экспортлогчдоо дэмжих. Өнөөдөр төмрийн хүдэр, жоншны салбар бүтээгдэхүүнээ борлуулж чадахгүй болчихсон. “Нүүрс араас нь орох нь.

Нэг мөсөн амыг нь барьж унагаах гэж байгаа юм байлгүй” гэдгийг хар алтаар амьдралаа төдийгүй улсынхаа төсвийг залгуулах гэж яваа нүүрсний салбарынхан өгүүлж байна. ■

## ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙ

# НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ЖИШИГ

### С.ЗАЯА

Өмнө зүгт үүрийн шаргал туяа тусч, гэгээн тунгалаг өглөө эхэлснийг илтгэх. Эргэн тойрон уулс, толгодоор хүрээлэгдсэн энэ газарт төрөл бүрийн ургамал цэцэгс ургажээ.

Алсаас барааг нь харж явсан уулын оройд гарч, сониучирхан үзвэл бэл, хормой хөндийгөөр нь харуулдсан мэт тэгшхэн талбай байх аж. Тэнд ургамал ногоо нэгэн жигд ургажээ. Байгаль эхийн өвөрмөц тогтоцийн нэг



Нөхөн сэргээлт хийсэн талбайд малын тэжээлийн ургамал тарьсан нь ийн ургажээ. 2014.10.18

► нь энэ бололтой хэмээн бодож зогсолт хажуудах хүн маань “Өнгөрсөн жил нөхөн сэргээсэн талбайд өвс, ургамал ийн ургажээ” гэв. Учрыг ойлгож ядаж байтал “Манайх олборлосон газраа тэр даруйд нь нөхөн сэргээлт хийдэг” хэмээн нэмж өгүүлэх. “Уул уурхайн үндэсний олборлогч” /MNO/ компани Төв аймгийн Заамар сумын нутаг Бага хайлаастын ам болон Баянголын аманд алтны шороон ордыг түшиглэн 2010 оноос хойш үйл ажиллагаа явуулж иржээ. Тус уурхайн нутаг дэвсгэр нь уулархаг, нарс, хайлаасан бяцхан төгөл бүхий ой хээрийн хэв шинжтэй бөгөөд хойд тал руугаа намсаж, голын хөндий рүүгээ нугархаг хээр талтай аж. Уулсын энгэр, бэл, хормой, хөндийгөөр хээрийн ургамал ургасан байх.

“Уул уурхайн үндэсний олборлогч” / MNO/ компани нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийж тухайн газрыг унаган төрхөнд нь ойртуулж, орон нутагт нь хүлээлгэн өгдөг байна. Тэд 2011 оноос хойш уурхайн олборлолтод өртсөн талбайг нөхөн сэргээж буй юм. Хамгийн эхэнд 2010

онд ашигласан 28.1 га талбайгаа дараа жил нь нөхөн сэргээсэн байна. Энэ талбайгаас одоо малчид хадлан тэжээлээ базаадаг болж. Ийм жишгээр ажилласаар тэд гурван жилийг үджээ. 2012 онд олборлосон газраа нөхөн сэргээж, ургамал ногоо хэрхэн ургасныг аравдугаар сарын 18-нд нутгийн иргэдэд танилцуулсан юм. Заамарынхан ч тэдний ажилд ам сайтай байна лээ. Энэ талаар хойно өгүүлэх учир түр азнаад нөхөн сэргээлт хэрхэн хийснийг танилцуулъя.

**Олборлолт явуулсан талбайн экосистемийг бий болгох нь цаг хугацаа, хүн хүч, хөрөнгө шаардсан нарийн ажил. Эхний жил нөхөн сэргээлт хийсэн талбайд тариалсан ургамлыг мал, амьтны хөлд гишгүүлэхгүйн тулд хамгаалалтад авдаг байна.**

Тус компани нөхөн сэргээлтийг уурхайн олборлолтын үйл ажиллагаатай уялдуулан гүйцэтгэж иржээ. Өөрөөр хэлбэл, техникийн нөхөн сэргээлтээр газрын хэвлийг унаган төрхөнд нь оруулж, хэлбэршүүлэх, гол мөрний голдирлыг сэргээж, шимт хөрсөөр хучдаг байна. Нэг ёсондоо шимт хөрсөө хуулаад овоолго болгож хадгалдаг гэсэн үг. Энэ овоолгоо нөхөн сэргээлт хийхэд эргүүлэн ашигладаг байна. Уулын нугачаатай хэсэгт шимт хөрс 70-80 см бол бусад хэсэгт 20-50 см-ийн зузаан байдаг аж. Тэд 50-60 метрийн гүнд олборлолт явуулж байна. Олборлосон талбайдаа маш хурдан хугацаанд нөхөн сэргээлт хийдэг нь тус компанийн давуу тал. Үүний дараа биологийн нөхөн сэргээлт хийдэг юм. Шимт хөрсөөр хучсан талбайд ургамал, ногоо, цэцэгс тарьжээ. Ойролцоогоор 10 гаруй төрлийн ургамал тариалдаг гэсэн. Хамгийн гол нь, олборлолт явагдах хугацаанд байгалийн бүс, бүслүүрийн онцлог бүхий талбайнуудыг уурхайн зарим хэсэг зориуд хөндөлгүйгээр үлдээж. Энэ нь экосистемийн нөхөн

сэргээлтийг үр дүнтэй болгох, байгалийн унаган төрхийг сэргээхэд чухал ач холбогдолтой болдог байна.

Олборлолт явуулсан талбайн экосистемийг бий болгох нь цаг хугацаа, хүн хүч, хөрөнгө шаардсан нарийн ажил. Эхний жил нөхөн сэргээлт хийсэн талбайд тариалсан ургамлыг мал, амьтны хөлд гишгүүлэхгүйн тулд хамгаалалтад авдаг байна. Мөн үерийн уснаас хамгаалах шуудуу татаж, тарьсан ургамлаа ургуулахад анхаардаг. Ийн хүч хөдөлмөр гаргаж, сайн ургуулсны дараачаас малчид хадлан хадах боломжтой болдог гэх. Нөхөн сэргээлт хийхдээ Австрали, Канадын уул уурхайн жишиг, менежментийг ашиглаж буй аж. Ингэхдээ орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах зорилгоор “Заамар арвижих” хоршоо болон тус суман дахь МСҮТ-ийн ойжуулалтын ангийн оюутнуудыг авч ажиллуулдаг байна. Тэд тухайн орчны тохижилт, мод тарихаас эхлээд явган хүний зам тавих ажилд хамтарчээ. Хамгийн сүүлд тус компани Заамар сумын “Багахайлааст”, “Баянгол”-ын уурхайд өнгөрсөн оны есдүгээр сард техникийн нөхөн сэргээлтийг 61.9, биологийн нөхөн сэргээлтийг 71.75 га-д хийгээд байна.

## Хөдөлмөрийн аюулгүй байдал хамгийн чухал

“Ах аа, та бүү яараарай”. “Аав аа, та сайн байна уу”, “Манайхаан бүү яараарай, анхаар, анхаар!!!”, “Залуус аа, амжилт хүсье” гэсэн үгийг тус компанийн ажилтнууд техник хэрэгсэл дээрээ наажээ. Энэ нь операторуудынх нь аюулгүй ажиллагаагаа хангах үүднээс анхааруулга, сэрэмжлүүлэг болгож бичсэн үг ч гэлээ хүнээ гэсэн компанийн удирдлагуудын сэтгэл харагдах. Нөгөөтэйгүүр энэ нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангаж ажиллах ёстойг ажилтнуудад ажилдаа гарах бүрт сануулах. Тус компани ажилтнуудаа эрүүл, аюулгүй ажиллах нөхцөлөөр хангаж ажиллахад байнга анхаарч, нэн тэргүүний зорилт болгон тавьжээ. Ингэхдээ тэдний ажлын байрны аюулгүй орчинг бүрдүүлэх, эрүүл мэнд болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд гарч болзошгүй эрсдэлийг багасгахад анхаардаг аж. Тэр ►



► үүднээс уурхайнхаа дэргэд эмнэлэг ажиллуулдаг байна. Мөн байгаль орчны лаборатори, засварын төвтэй. Ажилтнуудынхаа ая тухтай амрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Канад технологиор барьсан байр нь үнэхээр тухтай юм билээ.

Үүний зэрэгцээ “Уул уурхайн үндэсний олборлогч” /MNO/ компани нийгмийн хариуцлагын хүрээнд тус суманд бүтээн байгуулалтын маш олон ажил хийжээ. Өнгөрсөн онд л гэхэд 100 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна. Мөн тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй бизнес, аж ахуйн нэгжүүдийг дэмжиж ажилладаг аж. Дээр өгүүлсэн нутгийн иргэдэд компанийнхаа хийж буй ажлын талаар танилцуулсан өдөрлөг нэлээд үр дүнтэй болов. Энэ талаар тус компанийн гүйцэтгэх захирал Ш.Лхамсүрэн “Орон нутгийн ард иргэдэд хийж бүтээсэн ажлаа танилцуулж байна. Ингэснээр иргэдэд компанийнхаа талаар зөв ойлголтой болгох юм. Эл арга хэмжээг хоёр дахь

удаагаа зохион байгуулж байна. Энэ удаагийн арга хэмжээ үр дүнгээ өглөө. Нутгийн иргэд манай компанийн тухай зөв ойлголтой болох нь хамгийн чухал” гэв.

Манай улсад сүүлийн жилүүдэд уул уурхай эрчимтэй хөгжиж байна. Баялгийг нь аваад ухаж сэндийчсэн нүх, овоолсон шороо үлдээгээд явдаг

нэг хэсэг байхад хийсэн ажилдаа хариуцлагатай хандаж, байгаль эхийг унаган төрхөнд нь оруулахаар зүтгэдэг, хөдөлмөрлөдөг “Уул уурхайн үндэсний олборлогч” /MNO/ тэргүүтэй компаниуд ч байна. Энэ нь Монголд хариуцлагатай уул уурхай хөгжиж эхэлж буйн тод жишээ, томруун дүр төрх юм. Ийм компаниуд илүү олон болоосой.



## “Уул уурхайн үндэсний олборлогч” /MNO/ компанийн талаар Төв аймгийн Заамар сумын иргэд ямар бодолтой явдаг вэ?

### Заамар сумын ИТХ-ын дарга Н.Нямдорж



-Манай суманд уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулдаг “Уул уурхайн үндэсний олборлогч” компани нутгийн иргэдэд ажлын

“тайлан”-гаа тавьж байна. Тус компани 2013 онд “Улсын нөхөн сэргээх үзүүлэх сургуулилалт”-ыг амжилттай зохион байгуулсан. Нөхөн сэргээлтийг стандартын дагуу маш сайн гүйцэтгэдэг компаниудын нэг. Хариуцлагатай уул уурхай хөгжүүлж буй компанийн хувьд сум орон нутагтаа байнга хамтарч ажилладаг. Хамтын ажиллагааны хүрээнд өнгөрсөн жил манай сумын 90 жилийн ой болоход 100 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил хийсэн. Мөн энэ онд хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт хамтарч ажиллахаар хамтын ажиллагааны гэрээ байгуулаад байна. Түүнчлэн сум орон нутгийн дэд бүтцийн асуудлыг шийдэх үүднээс 20 айлыг хамруулж, жишиг хороолол бий болгохоор ажиллаж байгаа. Заамар суманд энэ жил 23 аж ахуйн нэгж уул уурхайн олборлолт явуулж

байна. “Уул уурхайн үндэсний олборлогч” компани манай суманд үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш цаг тухайд нь нөхөн сэргээлт хийж, хариуцлагатай ажиллаж ирсэн. Тус компанийн нөхөн сэргээлтэд манай сумын Засаг дарга болон ИТХ сэтгэл хангалуун явдаг юм.

### Заамар сумын Засаг даргын орлогч Ч.Баярцэцэг



-“Уул уурхайн үндэсний олборлогч” компани манай суманд 2011 оноос үйл ажиллагаа явуулж ирсэн. Энэ хугацаанд сум

орон нутагтаа хамтран ажиллахын зэрэгцээ биологийн болон техникийн нөхөн сэргээлтийг дээд зэргээр гүйцэтгэж ирсэн хариуцлагатай уул уурхайн компанийн нэг юм. Уул уурхайн нөхөн сэргээлт яаж хийж буйгаа иргэдэд үзүүлж байгаа нь үнэхээр сайхан ажил боллоо. Цаашлаад манай суманд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд тус компаниас үлгэр жишээ авч ажиллаасай. Олборлолт явуулж дуусаад нөхөн ►

▶ сэргээлт хийж буйд нь таатай байдаг.

**Төв аймгийн Заамар суман дахь МСҮТ-ийн захирал Ч.Энхбаатар**



-Миний бие мэргэжлийн боловсролын албанд 20 гаруй жил ажиллаж байна. Ажлаа аваад удаагүй байгаа ч тосон заамарт үйл

ажиллагаа явуулдаг компаниудынхаа үйл ажиллагаатай танилцаж байна. Үүний нэг нь “Уул уурхайн үндэсний олборлогч” компани юм. Тус компани манай МСҮТ-ийн гагнуурчны ангийг техник хэрэгслээр иж бүрэн хангаж өгсөн. Энэ нь манай сургалтын үйл ажиллагаанд тус нэмрээ өгч, чанартай, чадварлаг боловсон хүчин бэлтгэхэд үр шимээ өгч байна. Тус компанийн уурхайн олборлолтын ажил болоод нөхөн сэргээлтийн ажилтай танилцлаа. Өмнө нь би “Эрдэнэс Тавантолгой”, “Оюутолгой”-н үйл ажиллагаатай танилцаж байхад ийм орчин бүрдүүлсэн байсан. Өөрөөр хэлбэл, энэ уурхайнуудтай адил стандарттай явж байгаа юм байна. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах тал дээр олон улсын туршлага нэвтрүүлснийг нүдээр үзлээ. Ажилтнуудынхаа мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд анхаарч байгаа нь сайшаалтай санагдсан.

**“Тосон заамар” төрийн бус байгууллагын Удирдах зөвлөлийн гишүүн Энхтуяа**



-“Уул уурхайн үндэсний олборлогч” компанийн олборлолтын үйл ажиллагаа маш нарийн зохион

байгуулалттай явдаг юм билээ. Манай бичил уурхайчдад туршлагаас нь нэвтрүүлэх зүйл их байна. Тухайлбал, би олборлолтын үйл ажиллагаатай танилцлаа. Тэгэхэд хөдөлмөр хамгаалал маш сайн хангагджээ. Манай бичил уурхайчид энэ тал дээр учир дутагдалтай явж иржээ. Тэдэнд энэ талаар хэлэх, ярих, санаа авах зүйл их байгааг мэдэрлээ. Бичил уурхайчид нэгдсэн зохион байгуулалтад ороод хоёр жил болж байна. Манай төрийн бус байгууллага 25 гишүүнтэй.

**Ус, цаг уурын газрын Заамар суман дахь цаг уурын ажилтан Д.Жаргал**

-“Уул уурхайн үндэсний олборлогч” компанийн үйл ажиллагаа маш сайн. Бусад уурхайтай харьцуулахад тэс өөр юм. Нөхөн сэргээлт болоод компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд сэтгэл хангалуун явдаг. Ажилтнуудынхаа тав тухыг хангасан, хүний төлөө



ажилладаг хамт олон байна лээ. Газрын доорх баялгийг аваад ухаж сэндийчсэн нүх үлдээх бус байгалийг унаган төрхөнд нь оруулах гэж маш

их хөдөлмөр, зүтгэл гаргажээ. Мэргэжлийн хүний нүдээр харахад газрын налуу өөрийнх нь унаган төрхөнд дөхөж очихоор гаргаж. Хөрс талхлагдсан зүйл ч алга. Ургамлын даацын хэмжээ маш сайн байна. Олборлолтоо хийгээд нөхөн сэргээлтээ зэрэг гүйцэтгээд явж буй нь сайшаалтай. Ийм уурхай Монголд маш ховор.

**“Заамар арвижих” нөхөрлөлийн Удирдах зөвлөлийн гишүүн Л.Энхцэцэг**



-Манай нөхөрлөл 13 гишүүнтэй. Өмнө нь гар аргаар алт олборлож байгаад хэсэг бүлгээрээ нэгдээд нөхөрлөл байгуулсан. Бид

“Уул уурхайн үндэсний олборлогч” компанийн олборлолт явуулсан талбайд дахин хайгуул хийдэг. Үүнээс гадна тус компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд хийж буй зарим ажилд туслан гүйцэтгэгчээр оролцож байна. Тухайлбал, зам тавихаас эхлүүлээд багагүй ажил хийсэн.

**Заамар сумын IV багийн иргэн С.Лхам**



-“Уул уурхайн үндэсний олборлогч” компанид манай сумаас олон хүн ажиллаж, амьжиргаагаа залгуулдаг. Тус компани

нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутагт маш олон ажил хийсэн. Нөхөн сэргээлт хийсэн ажилтай танилцлаа. Олборлосон газраа хэвэнд нь оруулжээ. Ургамал, ногоо нь ч бүрэн гүйцэд ургасан байна. Эдний компанийн нөхөн сэргээлт хийсэн жишгийг бусад аж ахуйн нэгж судалж, нэвтрүүлмээр санагдлаа. Мал бэлчээрлэх бүхий л нөхцөл нөхөн сэргээлт хийсэн талбайд бүрджээ. Манай суманд олборлосон газартаа ядаж техникийн нөхөн сэргээлт хийсэн компани ховор байгаа энэ үед ийм ажлыг хийж буй нь хариуцлагатай уул уурхайн нэг хэлбэр юм уу даа. Аюул осолгүй, хөдөлмөр хамгааллыг чанд мөрдөж ажиллахаас эхлүүлээд олон хүчин зүйл хариуцлагатай уул уурхайг бий болгодог байх. Энэ бүхэн “Уул уурхайн үндэсний олборлогч” компанид бүрдсэн гэж бодож байна. ■

## ХӨГЖЛИЙН ГАЙХАМШИГ

# БООЛООС “БОСС” ОРОН

## Б.ЭНХЦЭЦЭГ

Сингапурыг “Азийн харанхуй буланд орших жижиг агаад ядуу зах зээл” гэж 1960 онд Голландын эдийн засагч доктор Алберт Винсэмюс тодорхойлж байсан. Тэрбээр Нэгдсэн Үндэстний байгууллагын өгсөн үүрэг даалгаврын дагуу хүндрэлд орсон арлын эдийн засгийг аврахаар ирэхдээ ийнхүү тухайн үеийн Сингапурыг дүрслэн хэлж байв.

Үүнээс хойш таван 10 жил өнгөрөхөд Сингапур хэмээх хот улс ядуу мөн жижиг зах зээлийн аль нь ч биш болсон бөгөөд нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээгээр дэлхийн эхний долоод бичигдэж, зургаан өрх тутмын нэг нь сая ам.доллараас давсан хадгаламжтай улс болж чадсан байдаг. Зөвхөн өнгөрсөн арван жилийг харахад сингапурчуудын эрхэлдэг хувийн бизнесүүд хоёр дахин тэлж, нэг хүнд ногдох ажил олгогч эздийн тоогоор АНУ-ын дараа буюу хоёрдугаарт орох болсон. Тус улсыг гуравхан хүчин зүйлээр тодорхойл гэвэл өндөр боловсрол, өндөр технологи, өндөр боломж гэж хэлж болох юм.

“Хөгжил” клубын гаднын улсуудын туршлагыг судлах ээлжилт уулзалтын үеэр гишүүн Э.Эрдэнэчимэгийн тавьсан илтгэлээс үзэхэд тус улсын хөгжлийн стратеги нь тун энгийн. Хүн амынхаа боловсролын түвшинг ахиулах, Үндэстэн дамнасан корпорациуд Сингапурт үйл ажиллагааныхаа төвийг байрлуулахыг дэмжих, хөгжиж буй хөрш орнуудын зах зээлд хөрөнгө оруулах, дэвшилт, өртөг нэмсэн технологид гадаадын хөрөнгө оруулалтыг чиглүүлэх зэрэг багтдаг байна.

Тус улсад ихэнх орны иргэд визгүй зорчдог. Түүнчлэн хамгийн аюулгүй

хотуудын нэг бөгөөд дэд бүтэц сайн хөгжсөн байхаас гадна гадаадын иргэдэд хандах хандлагаараа хамгийн ээлтэй оронд тооцогддог учир гаднынхан ирж, очих, бизнес эхлүүлэхэд нэн тохиромжтой. Сингапур улс зөвхөн гаднаас хөрөнгө оруулалт татаад зогсохгүй гадагш чиглэсэн хөрөнгө оруулалтыг дэмждэг. Түүнчлэн хөрш улсууд, тэр дундаа Хятад, Малайз, Энэтхэг болон Индонез зэрэг улсыг хараалж,

зээл, татварын хөнгөлөлт, Засгийн газрын батлан даалт, даатгал зэрэг хүчин зүйлээр дэмжих бодлого барьж байна. Мөн хөрш орнуудтай өртөг нэмсэн бараа, үйлчилгээг харилцан худалдаалах зарчмаар олон талд ашигтай ажиллагаа явуулдаг байна.

Бусад Лондон, Нью-Йорк Шанхай зэрэг боомт хотын адилаар Сингапур нь дэлхийн тээвэрлэлтийн сүлжээнд ашигт малтмал ихтэй орнуудыг ▶



► холбосон байдаг. Сингапурын эцэг хэмээн нэрлэгддэг Томас Стэнфорд Рафлес 1823 онд албан ёсоор тус улсыг чөлөөтэй, нээлттэй боомт хэмээн тунхаглан зарласан. Тэрбээр үүнийхээ учрыг тухайн үед “Би Сингапурыг бүх улс үндэстэнд эрх

**Зөвхөн өнгөрсөн арван жилийг харахад сингапурчуудын эрхэлдэг хувийн бизнесүүд хоёр дахин тэлж, нэг хүнд ногдох ажил олгогч эздийн тоогоор АНУ-ын дараа буюу хоёрдугаарт орох болсон.**



тэгш хандсан, худалдаа үйлдвэрлэлд татвар ногдуулдаггүй, аль ч орны хөлөг онгоцууд чөлөөтэй зорчих боломжтой боомт улс болгон зарласан. Энэ нь Сингапурын ирээдүйн өсөлтийн үр, хөгжил баялгийн баталгаа байх болно” хэмээж байжээ. Тэгвэл өнөөдөр түүний үг, өгүүлбэр үсэг гээлгүй биеллээ олоод буй. Тиймээс тус улсын эдийн засгийн амжилтыг “гайхамшиг” гэж нэрлэдэг. Учир нь, Сингапурт бусадтай харьцуулахад байгалийн баялаг, хүний нөөц, хөрөнгө, газар нутаг гээд ер нь бараг юу ч байгаагүй гэдэг. Харин зөв менежмент л эрийн цээнд хүргэж, эдийн дээдийг иргэдэд нь атгуулсан. Энэ бол түүх мөн сургамж.

### Тэвчээр ба ашиг: Сингапур

Газрын баялаг, мал аж ахуй, удам газар гэх зэрэг монголчуудад харамгүй заяасан хосгүй баялаг байгаагүй ч тэд үйлчилгээ болон дэвшилтэт, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн, тэр дундаа машин, техник тенологийн үйлдвэрлэлт мөн гаалийн чирэгдэл багатай далайн тээвэр, худалдааг тэргүүлэх салбараар тодорхойлж авч явсан байдаг. Тус улсын экспортод одоогоор газрын тосны боловсруулсан бүтээгдэхүүн, электрон бараа голлож буй. Азийн бар улсад үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний ДНБ-д эзлэх жин 25 хувиас бууруулахгүй байх бодлогыг Засгийн газраас нь барьдаг. Энэ оны байдлаар Сингапурын

үйлдвэрлэл 29.4 хувийг эзэлж байгаа бол, үйлчилгээ 70.6 хувийг “дааж” байна.

Азийн хоёр дахь хамгийн жижиг улс болох Сингапур улс нь 707 км.кв газар нутагтай бөгөөд энэ нь манай улсын нийслэл Улаанбаатар хотынхоос зургаа дахин бага газар нутаг гэсэн үг. Газар нутаг тэдэнд хөгжихөд саад болоогүй бөгөөд өнөөдөр нэг хүнд ногдох ДНБ-ий жилийн дундаж хэмжээ манай улсынхаас 10 дахин илүү байгаа нь дээрхийг гэрчлэх наад захын жишээ.

Тус улс байгалийн баялгийн эх үүсвэргүй, хүн ам цөөтэй, мөн газар нутгийн хэмжээгээр хамгийн жижиг улсуудын нэгт ордог бөгөөд олон зууны турш эрхэлж ирсэн уламжлалт тулгуур салбар гэж байхгүй. Өөрөөр хэлбэл, тэд бүхнийг шинээр эхэлж, нарийн төлөвлөх хэрэгтэй болсон. Байхгүйн зовлонгоос байхын жаргалд хүрч чадсан орон. Тиймээс өнөөдөр Азийн бар хэмээн “авгайлдаг”.

Аливаа улсын амжилтыг иргэдийнх нь амьдралын түвшин, сонголт, боломж олдох нөхцлөөр дүгнэх нь бий. Сингапурчуудын 35-44 насны иргэдийн дөрөвний нэг нь бизнес эхлүүлэхээр төлөвлөдөг бөгөөд тэдний зургаан хүн тутмын нэг нь аль хэдийнэ амжилттай үйл ажиллагаа эхлүүлчихсэн байдаг гэнэ. Тус улсын хүмүүс нь дэлхийн хамгийн өндөр орлоготой болон амьжиргаа сайтай иргэдтэй улсын тоонд дээгүүр жагсдаг. НҮБ-ын “Хүний хөгжлийн үзүүлэлт 2014”-г Сингапур ►

Харьцуулсан үзүүлэлтүүд	Сингапур	Монгол
Газар нутгийн хэмжээ	707.1 км <sup>2</sup>	1.566.500 км кв
Хүн ам/2013	5.3 сая	2.8 сая
ДНБ-ий жилийн дундаж өсөлт	6.86%	6.12%
ДНБ-ий хэмжээ/ 2013	297.9 тэрбум \$	11.5 тэрбум \$
ДНБ-ий хэмжээгээр олон улсад эзлэх байр/2013 оны байдлаар	36	130
Инфляци	0.60%	13%
Зээлийн хүү	0.07%	12%
Засгийн газрын өрийн хэмжээ ДНБ-тэй жишсэн дүнгээр	105.50%	51.70%
“Бизнес эрхлэлтийн орчны тайлан 2015” жагсаалт	1	72
Өрсөлдөх чадварын тайлан дахь үзүүлэлтээр 2014-2015	2	107
Компанийн татвар	17%	25%
Хүн амын орлогын ангилал дэлхийд/2013	Өндөр орлоготой	Бага ба дунд орлоготой
Хувь хүний орлогын албан татвар	20%	10%

► улс есдүгээр байрт жагсаж гурван байраар хөгжлөө ахиулж чадсан бол манай улс 103-т байна. Энэ цаг үеийн шинэ чиг хандлагаас үзэхэд улсын хөгжлийг зөвхөн ДНБ-ээр нийт хэмжих нь учир дутагдалтай гэх болсон бөгөөд хүний хөгжлийн үзүүлэлтийг мөн харгалзаж үнэлэх нь бодит гэж олон улсын мэргэжилтнүүд үзэх болсон.

Сингапурын энэхүү амжилтад хүрсэн нууц жор нь юу байв хэмээн хүмүүс ихэд сонирхох боловч үнэндээ гоц гойд жор гэхээсээ илүү зоримог шийдвэр, бодлого л суурь нь болж өгсөн байдаг. Тус улсын удирдлагууд тэвчээр заан боол орноос босс орон болохоор төлөвлөж, хүлээж, хийж, өнөөдөр ийн хүрсэн байдаг. Тэд олон зууны турш нэг орны хаяанаас нөгөө орны нөмрөг дор орж, нэгээс нөгөө рүү бөмбөрсний эцэст 1965 онд Малайзаас салан тусгаарлаж,

болж өгсөн. Сингапурын эдийн засаг нь Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөний үзүүлэлтэд хоёрдугаарт жагсдаг. Бизнес эхлүүлэхэд ердөө гуравхан өдөр ордог бөгөөд энэ нь дэлхийн дунджаас бараг арав дахин бага байгаа юм. Тиймээс тус улсыг бизнест ээлтэй эко тогтолцоотой орон гэдэг.

Сингапур бодлогоор 1960-1980 оны хооронд олон улсын үндэстэн дамнасан корпорациуд, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг эрчимтэй татсан бөгөөд 1970-аад оноос шинээр үйлдвэржсэн орнуудын нэг гэгдэх болсон. Үүний дүнд одоогийн өндөр хөгжсөн, технологид суурилсан эдийн засаг хөл дээрээ босчээ.

Өнөөдөр Сингапур улсын бүрдүүлж чадсан хууль эрх зүй, бизнесийн хүчтэй бодлого мөн олон оронтой

гаргаж. Тус улс Монгол шиг цөөн хүн амтай. Гэхдээ иргэдийнх нь дийлэнх нь дундаас дээш түвшний ажил эрхэлдэг бөгөөд бусад төрлийн ажлыг хөрш орнуудын иргэдээр хийлгүүлэх бодлого барьдаг байна. Таван сая хүн амтай тус улсад 1.3 сая гадаадын иргэнийг ажиллуулдаг. Манай улс гурван сая орчим хүн амтай бөгөөд жилдээ 200 мянган хятад ажилчин орж ирэхэд үндэсний аюулгүй байдлын тухай өндөр дээд хэмжээнд авч үзэхийг шаардан эмээцгээж эхэлдэг.

Тусгаар тогтносноос хойшхи 50 дахь жилтэйгээ золгох гэж буй тус улс нээлттэй хаалганы бодлого хэрэгжүүлснийхээ үр дүнг өндрөөр “амсч” сууна. Тэд болгоомжтойгоор боломжоо ахиулж, хөгжлөө дээш хөтлөхийг эрмэлзэхээс биш хандлага даган хазайж, хэлбийнэ гэж үгүй. Сингапурчууд бүсийн бүх улстай

Хятад, Япон, Англи, Их Британи зэрэг олон орны малгай дор нугдайж байсан сингапурчуудын ахархан хугацаанд их гүрэн болж чадсан ерөнхий бөгөөд энгийн гаргалгаа нь хувийн хэвшлийг хөхиүлэн дэмжих байв.



тусгаар тогтнолоо зарласан. Хятад, Япон, Англи, Их Британи зэрэг олон орны малгай дор нугдайж байсан сингапурчуудын ахархан хугацаанд их гүрэн болж чадсан ерөнхий бөгөөд энгийн гаргалгаа нь хувийн хэвшлийг хөхиүлэн дэмжих байв. Тус улс бизнес эрхлэгчдэд нэн таатай хууль эрх зүй, татварын эко орчныг бүрдүүлж өгсөн нь төсвийн орлогыг нь эрс багасгасан ч, ирээдүйн хөгжлийг нь түлхүүрдсэн гол хүч

хиллэдэг стратегийн онцгой байршил, баян далайн боомт, чадварлаг ажиллах хүч, таатай татварын тогтолцоо олон бизнес эрхлэгч тус улсыг гэрээ болгож, компанийнхаа төв оффисийг байрлуулах үндэслэл болсоор байна. Тэд татварын бодлогоо зөөллөснөөр, төсвөө дутааж, гаднынханд эзлэгдэнэ гэж айсангүй. Харин ирээдүйд хөрөнгө оруулалт, хөгжил болон ирнэ гэж итгэсэн учраас ийм шийдвэр

сайн найзын харьцаатай. Мөн тэдэнд дэлхийн хамгийн ухаантай, шилдэг хүмүүс өөрийн болон олон улсын хөрөнгө оруулалтын нөөц боломж бий. Ийм нөхцөлд тэд буцаж буурах үндэсгүй.

Харин шинээр цойлон гарч ирж буй монголчуудын хувьд бусдын хэлтгий гишгэсэн мөрийг судлан суралцаж, гаргасан алдааг нь давтахгүй, хүрсэн амжилтыг нь бататгаж, дараагийн Сингапур болох нь чухал. ■

# “ЧИНГИС” БОНДЫН ЗАРЦУУЛАЛТ

“Чингис” бондын төлбөрийг манай улс 2018, 2022 онд төлнө. Бонд гаргасан буюу 2012 онд нэг ам.доллар 1380 орчим төгрөгтэй тэнцэж байсан бол одоо 1860 даваад байна.

Гэхдээ бондын эргэн төлөх төсөөлөл, хүүгийн төлбөрийн тооцоог Монгол Улсын Хөгжлийн банкны мэргэжилтнүүд ийн хийжээ.

## Бондуудын эргэн төлөлтийн чадавхийн төсөөлөл /Чингис бонд+ХБ-ны 580 сая ам.долларын бонд/

Он	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014
ДНБ, оны үнээр, тэрбум төгрөг	3,041.41	4,027.56	4,956.65	6,555.57	6,590.64	8,414.50	11,087.72	14,012.90	17,550.17	21,213.39
ДНБ-ны өсөлт, оны үнээр, хувь	28.81%	32.42%	23.07%	32.26%	0.53%	27.67%	31.77%	26.38%	25.24%	20.87%
Нэгдсэн төсөв, тэрбум төгрөг	764.60	1,237.01	1,747.31	2,466.77	2,336.63	3,080.69	4,997.04	6,017.80	6,177.98	7,293.90
Нэгдсэн төсөв /ДНБ, хувь	25.14%	30.71%	35.25%	37.63%	35.45%	36.61%	45.07%	42.94%	35.20%	34.38%
Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардал, тэрбум төгрөг	89.82	175.67	299.50	624.39	460.56	591.04	1,280.92	1,525.36	1,447.34	2,006.20
Бондын хөрөнгө оруулалт, тэрбум төгрөг	-	-	-	-	-	-	-	488.35	1,667.15	2,174.49
Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардал+бондын хөрөнгө оруулалт, тэрбум төгрөг	-	-	-	-	-	-	-	2,013.71	3,114.49	4,180.69
Төсвөөс төлөх ЧБ, ХБ-ны бондын хүү+эргэн төлөлт, тэрбум төгрөг	-	-	-	-	-	-	-	-	22.8	93.4
Бондуудын хүү+эргэн төлөлт /төсвийн хөрөнгийн зардал, хувь	-	-	-	-	-	-	-	0.00%	1.58%	4.66%
Бондуудын хүү+эргэн төлөлт/ нийт хөрөнгө оруулалт, хувь	-	-	-	-	-	-	-	0.00%	0.73%	2.23%
Бондуудын хүү+эргэн төлөлт /нэгдсэн төсөв, хувь	-	-	-	-	-	-	-	0.00%	0.37%	1.28%
Бондуудын хүү+эргэн төлөлт /ДНБ оны үнээр, хувь	-	-	-	-	-	-	-	0.00%	0.13%	0.44%

Он	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
ДНБ, оны үнээр, тэрбум төгрөг	25,456.07	30,547.28	36,656.74	42,155.25	48,478.54	55,750.32	64,112.87	73,729.80
ДНБ-ны өсөлт, оны үнээр, хувь	20.00%	20.00%	20.00%	15.00%	15.00%	15.00%	15.00%	15.00%
Нэгдсэн төсөв, тэрбум төгрөг	8,696.80	10,041.80	11,287.21	12,122.71	13,020.06	13,983.84	15,018.95	16,130.69
Нэгдсэн төсөв /ДНБ, хувь	34.16%	32.87%	30.79%	28.76%	26.86%	25.08%	23.43%	21.88%
Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардал, тэрбум төгрөг	2,809.80	3,246.30	3,286.02	3,529.25	3,790.50	4,071.08	4,372.43	4,696.09
Бондын хөрөнгө оруулалт, тэрбум төгрөг	2,200.00	2,200.00	2,200.00	2,500.00	2,500.00	2,500.00	2,500.00	2,500.00
Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардал+бондын хөрөнгө оруулалт, тэрбум төгрөг	5,009.80	5,446.30	5,486.02	6,029.25	6,290.50	6,571.08	6,872.43	7,196.09
Төсвөөс төлөх ЧБ, ХБ-ны бондын хүү+эргэн төлөлт, тэрбум төгрөг	100.9	101.5	526.0	68.1	68.1	68.3	68.1	1,164.9
Бондуудын хүү+эргэн төлөлт /төсвийн хөрөнгийн зардал, хувь	3.59%	3.13%	16.01%	1.93%	1.80%	1.68%	1.56%	24.81%
Бондуудын хүү+эргэн төлөлт/ нийт хөрөнгө оруулалт, хувь	2.01%	1.86%	9.59%	1.13%	1.08%	1.04%	0.99%	16.19%
Бондуудын хүү+эргэн төлөлт /нэгдсэн төсөв, хувь	1.16%	1.01%	4.66%	0.56%	0.52%	0.49%	0.45%	7.22%
Бондуудын хүү+эргэн төлөлт /ДНБ оны үнээр, хувь	0.40%	0.33%	1.43%	0.16%	0.14%	0.12%	0.11%	1.58%

## Чингис бондын үндсэн хүүгийн болон хүүгийн төлбөр

	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	Нийт
ЗГ-аас ХО нарт төлөх төлбөр /сая ам.доллараар/	71.88	71.88	71.88	71.88	71.88	551.25	51.25	51.25	51.25	1,051.25	2,115.63
Хүүгийн төлөлт	71.88	71.88	71.88	71.88	71.88	51.25	51.25	51.25	51.25	51.25	615.63
5 жилийн хугацаатай 500\$	20.63	20.63	20.63	20.63							103.13
10 жилийн хугацаатай 1000\$	51.25	51.25	51.25	51.25	51.25	51.25	51.25	51.25	51.25	51.25	512.50
Үндсэн төлбөр	-	-	-			500.00	-	-	-	1,000.00	1,500.00
5 жилийн хугацаатай 500\$						500.00					500.00
10 жилийн хугацаатай 1000\$										1,000.00	1,000.00
МБ, ХБ-аас ЗГ-аар дамжуулан төлсөн хүүгийн төлбөр /сая ам.доллараар/	71.88										71.88
Хүүгийн төлөлт	71.88										71.88
Монголбанкнаас \$ (сая)	52.96										52.96
Хөгжлийн банкнаас \$ (сая)	4.82										4.82
Хөгжлийн банкнаас ₮ (тэрбум)	23.38										
Үндсэн төлбөр	-	-	-	-	-	-	-	-	-	-	\$
Хөгжлийн банкнаас \$ (сая)											
Хөгжлийн банкнаас ₮ (тэрбум)											

## ДҮН ШИНЖИЛГЭЭ

# МАКРО ЭДИЙН ЗАСГИЙГ ТОГТВОРЖУУЛАХ НЬ

Нэгдүгээр хэсэг

## Үндэсний стратегийн хүрээлэн/ҮСХ/- гийн хөндөж буй асуудал

2011-2013 оны эдийн засгийн үсрэнгүй өсөлт, эрчимтэй хөгжил, их хэмжээний гадаадын хөрөнгө оруулалт, үндэсний мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдалтай харьцуулахад өнөөгийн эдийн засгийн ерөнхий байдал муудаж, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд буурлаа. Монгол Улсын эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахын тулд макро эдийн засгийн ямар бодлого, эдийн засгийн чиглэлтэй байх нь зохистой вэ?

## Зохиогчийн байр суурь

Эхлээд эдийн засгийн өсөлтийн гол үзүүлэлтүүдийг харахад, 2011 онд эдийн засаг 17,3 хувийн өсөлттэй байсан бол 2012 онд 12,3 хувь, 2013 онд 11,6 хувь өсчээ. Гэвч 2014 оны байдлаар эдийн засгийн өсөлт 5,3 хувь хүртэл буурахаар байгаа нь дэлхийн олон эдийн засаг хямралтай байсан 2010 оны манай орны өсөлтийн түвшингээс ч буурна гэсэн үг юм.

Өнөөгийн байдлаар гол санаа зовоож байгаа зүйлүүд гэвэл,

- Эдийн засгийн өсөлтийн хурд жил ирэх тусам буурсан
- Инфляци өсч, үнийн түвшин 14,9 хувиар нэмэгдсэн
- 2013 оны байдлаар ДНБ-д эзлэх улсын төсвийн алдагдал 10 хувь болж өссөн /Дэлхийн банкны дөрөвдүгээр сарын тайлан мэдээгээр/
- Монголын гадаад худалдааны эргэлт алдагдалтай хэвээр, дээрээс нь дотогшлох хөрөнгийн урсгал ихээхэн багассан.
- Улсын валютын нөөц буурч, үндэсний валютын ханш 30 хувиар суларсан
- Энэ оны зургаадугаар сарын байдлаар улсын өр ДНБ-ий 67 хувьд хүрсэн /ОУВС-гийн мэдээгээр/
- Банкны салбар дахь найдваргүй болон хугацаа сунгасан зээлийн хэмжээ нэг их наяд төгрөгт хүрсэн нь ирээдүйд энэ салбарын толгойны өвчин болох нэг томоохон хүчин зүйл юм.

Энэ бол ерөнхийн макро эдийн засгийн дүр зураг. Гэтэл эдийн засагт баялаг бүтээдэг, уул уурхайгаас бусад салбарын байдлыг харахаар, эдийн засаг хүнд байдалд орж байгааг илтгэх олон шинж тэмдэг байна. Дээрх эдийн засгийн өсөлтийн тооноос сүүлийн жилүүдэд бий болгосон уул уурхайн хэсгийг хасвал, үл хөдлөх хөрөнгө болон бусад салбарыг авч үзэхэд байдал улам хүндрэлтэй болж байгаа, иргэдийн эрэлт, худалдан авах чадвар нь илт буурч байгаа нь ажиглагдаж байна. Тухайлбал,


- -Хэдийгээр үнэ огцом өссөн ч бөөний болон жижиглэнгийн худалдааны борлуулалт бараг өсөөгүй, орон нутагт буурч байна.
- -2014 оны эхний долоон сарын байдлаар төмөр замын ачаа эргэлт болон зорчигч тээвэрлэлт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 12 хувиас долоон хувь болж буурсан.
- -Ресторан, цайны газруудын гүйлгээ 14 хувиар буурсан
- -Нийтийн хоолны салбарын уналт 62 хувьд хүрсэн бол зочид буудлуудын орлого 21 хувиар буурчээ.

Салбаруудын өсөлтийн хүнд байдал ажил эрхлэлт болон хөдөлмөрийн хөлсний статистик үзүүлэлтэд ч харагдаж байна.

- -2012 онтой харьцуулахад ажилгүй болон ажил хайж байгаа иргэдийн тоо 39 мянгаас 55 мянга болон нэмэгдсэн бөгөөд шинээр бий болсон ажлын байрны тоо хоёр дахин буурчээ.
- -Ажилгүйчүүдийн 69 хувь нь ид насны хөдөлмөрлөх чадвартай 15-34 насны залуус байна.

Тээврийн салбарт үндэсний агаарын тээврийн том компанийн нэг болох “Изинис” энэ онд дампуурсан бөгөөд ийм байдал удаан үргэлжлэх юм бол бусад компани ч хүнд байдалд орохоор байна. Барилгын салбар хүнд байдалд орлоо. Ямар ч бодлого, тооцоогүйгээр иргэдэд орон сууцны найман хувийн хөнгөлөлтийг үзүүлсэний үр дүнд байрны үнэ өсч, эрэлт хэт их болсны дараа энэхүү хөнгөлөлтийн хугацаа, эх үүсвэрийг багасгахаар нийт борлуулалт багасч, байрны үнэ буух болсон нь барилгын салбарын үйл ажиллагааг ихээхэн савалгаанд оруулж, хурдацтай өсч байгаа чанаргүй зээлийн давалгаанд өртөх аюултай болголоо. ▶

Өнөөгийн байдлаар эдийн засгийн өсөлтөд Оюутолгойн экспортолж буй алт, зэсийн хүдэр гол үүрэг гүйцэтгэж байгаа ч энэ нь бараг цорын ганц гэрэл гэгээ болоод байна. Дараах графикт Дэлхийн банк ДНБ-ий өсөлтийн байдлыг уул уурхайн салбарыг оруулалгүйгээр үзүүлжээ. Эндээс харахад уул уурхайн салбарыг хасахад л эдийн засгийн өсөлт /цэнхэр зураас/ хасах үзүүлэлт рүү орохоор харагдаж байна.



Үүнээс хэлэх гол зүйл гэвэл “эдийн засгийг солонгоруулах” гэсэн нэртэй бодлого 2012 оноос нэлээд яригдаж байсан ч эдийн засгийг төрөлжүүлэх буюу олон салбарын өсөлтийг түших бодлого одоогоор хувь нэмрээ өгч эхлээгүй, олборлох салбарын өсөлтийг тооцохгүйгээр эдийн засгийн өндөр өсөлт хангалттай түвшинд байж чадахгүй байна. Хөдөө аж ахуйн болон бусад салбарын нөөц боломжийг одоогоор дотоод зах зээлд ч, гадаад зах зээлд ч ашиглаж эхлээгүй байна. Тэгэхээр эдийн засгийн өсөлтийг тогтворжуулах, үйлдвэрлэл, төрөлжилтийг жинхэнэ утгаар дэмжих, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах нь өнөөдөр анхаарлыг татах гол асуудал болж байгаа юм.

Макро эдийн засгийн тогтвортой байдлын талаар жилдээ нэг, хоёр удаа ярьж байна. Ирэх оны улсын төсөв, мөнгөний бодлогыг хэлэлцэх үед л энэхүү сэдэв УИХ-ын анхааралд ордог. Макро эдийн засгийн тогтвортой байдал өнөөдөр жирийн иргэдийн амьдралд ихээхэн сөргөөр нөлөөлж эхэллээ.

ДНБ-ий өсөлт нь дангаараа макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангагч биш. Үүнтэй цогцоор байх ёстой голлох бусад макро эдийн засгийн үзүүлэлт ихээхэн муудаж байгаа нь нийт эдийн засгийн байдлыг дордуулахад нөлөөлж байна. Үүнд төсвийн алдагдал, асар их хэмжээгээр нэмэгдсэн, улсын гадаад болон дотоод өр, үнийн өсөлт, түүнтэй холбоотой амьжиргааны түвшний бууралт, ажилгүйчүүд өсөж байгаа цагт Монгол Улс макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж чадахгүй.

Төрийн хөрөнгө оруулалтаар эдийн засгийн өсөлтийг дэмжих, зөвхөн өндөр өсөлтөөр хөгжлийг хангана гэдэг зохимжтой хэлбэр биш. Тэр тусмаа манай нийт хөрөнгө

оруулалтыг татдаг олборлох салбар зогсонги байдалд орсон, гадаадын хөрөнгө оруулалт ихээхэн буурсан үед. Энэ нь эцсийн дүндээ зөвхөн төсвийн алдагдал өрийг улам нэмэгдүүлэх талтай. Шийдэл нь нийт макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахын тулд бусад салбарын өсөлтийг дэмжих, эдийн засгийн өсөлтийн олон эх үүсвэрийг бий болгож, олон төрлийн хөрөнгө оруулалтыг дэмжих орчинг бүрэлдүүлэхэд оршиж буй. Үүнийг л макро эдийн засгийн тогтвортой байдал гэж ойлгож болно.

Гадаадын хөрөнгө оруулагчдыг татах нь Монголд чухал. Харин эдгээр хөрөнгө оруулагч /зээлдэгч/ нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг хэрхэн удирдаж байгааг анхааралтай судалдаг. Аливаа дотоодын хөрөнгө оруулалтын тухайд зах зээл дээр эрэлт байна уу, хүмүүсийн худалдан авах чадвар нь байна уу гэдгээс мөн эхэлдэг. Иймээс уул уурхайгаас бусад салбарын өсөлтийг хангах, хөрөнгө оруулалтыг татах гол нөхцөл бол макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах юм.

Макро эдийн засгийн тогтворжилтыг хэд хэдэн үзүүлэлтээр хэмждэг. Тухайлбал, Европын холбооны Маастрихтийн хэлэлцээрт тусгаснаар макро эдийн засгийн тогтвортой байдлыг дараах дөрвөн хүчин зүйлээр үздэг.

**Урьдчилан сэргийлж чадалгүйгээр эдийн засаг бүрэн унах дээрээ тулвал “Гарц стратеги” хэрэгтэй болох бөгөөд энэ нь ихээхэн хэмжээний зардлын хэмнэлтийг шаардана. Үүнээс болж бодит цалин буурч, нийт ард иргэдийн амьжиргаа доройтож байна.**

**Нэгдүгээр хүчин зүйл. Инфляцийг бага хэмжээнд, тогтвортой байлгах**

Инфляцийг хазаарлаж, үндэсний валютыг дэмжих нь эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажлын байрыг шинээр бий болгох үндсэн зорилгын нэг. Үнийн тогтвортой байдал /инфляцийг хянах/, мөн үндэсний валютын тогтвортой байдал нь Монголын Төвбанкны үндсэн үүргийн нэг юм. Инфляциас болж үндэсний мөнгөн тэмдэгтийн ханш унах нь манайд импортын үнийг улам нэмэгдүүлэх гол шалтгаан болно. Өнөөдрийн байдлаар Монголын инфляци 14,9 хувьд хүрээд байгаа нь нэг жилийн дотор манай компани, аж ахуйн нэгж, айл өрхийн бодит худалдан авах чадвар 1/7-ээр буурсан гэсэн үг. Тэгэхээр цаашид зах зээл улам хумигдана. Гэтэл Европын холбоо инфляцийн зохистой түвшинг Маастрихтийн гэрээгээр гишүүн орнуудын хувьд гурван хувь гэдэг. Тиймээс манай улсын хувьд инфляцийг бууруулах нь эдийн засгийн бодлогын төвд байх ёстой.

**Хоёрдугаар хүчин зүйл. ДНБ-тэй харьцах улсын өрийн хэмжээ бага байх**

Улсын өрийн хэмжээ бага түвшинд байснаар татварын орлогыг өрийн төлбөрт биш, дотоодын хэрэгцээ, хөрөнгө оруулалтад зарцуулах боломжийг Засгийн газарт олгодог. ▶

► 2003-2012 онд Монголын Засгийн газрын өр бага хэмжээнд байсан бөгөөд улсын хөрөнгө оруулалт энэ хугацаанд бараг 100 дахин өссөн гэсэн тооцоо байдаг.

Гэтэл ДНБ нь 10 тэрбум ам.доллараар хэмжигдэж байгаа Монголын Засгийн газрын 2012 оноос хойш тавьсан гадаад өрийн хэмжээ 2,4 тэрбум ам.долларт хүрээд байна. Энэ өрийг дарах үүрэг дараа дараагийн Засгийн газрын нуруун дээр байх болно. Одоогийн нөхцөлд энэ өрийг аль болох ашиг гаргах, улмаар ДНБ-ийг нэмэгдүүлэх зүйлд зарцуулах, тухайлбал, ажлын байр шинээр бий болгох, татварын бааз суурийг өргөтгөхөд зарцуулах нь туйлын чухал байна. Их өрийг төсвөөс төлөх ёстой бөгөөд 2017 оноос үндсэн өрөө төлж эхлэх үед эдийн засгийн байдал хүндрэх, дараагийн Засгийн газруудын хөрөнгө оруулах боломж нь эрс хумигдах аюултай. Учир нь, төсвийн орлогын нэлээд хувийг өр болон түүний хүүг төлөхөд зарцуулахаас өөр аргагүй болно. Одоогийн байдлаар үүссэн өрийн хэмжээ Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын нийт дөрвөн жилийн дүнтэй тэнцэж байна. Өөрөөр хэлбэл, дараагийн Засгийн газар ямар ч хөрөнгө оруулалт хийхгүй, зөвхөн өрийг дарахад л хангалттай мөнгөтэй байна гэсэн үг. 2016 оноос хойш сургууль, соёлыг хөгжүүлэх, төсвөөс хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, дэд бүтцийг сайжруулах үндсэн ажлууд эх үүсвэргүй болж байна гэсэн үг. Сүүлийн хоёр жилд Засгийн газрын нэмэлт зээлийн зардал мэдэгдэхүйц өслөө. Өрийн оновчтой удирдлагын стратеги, улсын хөрөнгө оруулалтын бодлого одоо нэн чухал байна. Их өрийн хэмжээ хувийн хэвшилд ч бас сөрөг нөлөө үзүүлж эхэлж байна. Монголын өр нэмэгдсээр байх аваас хөрөнгө оруулагчид болон банкууд Монголын эрсдэлийг өндөр хэмээн үнэлж, өндөр хүүтэйгээр зээл олгох болно. Гэхдээ ийм зээлдэгч олдвол шүү дээ. Тэгэхээр их өрийн цаад утга нь зөвхөн улсын хөрөнгө оруулалт хумигдах төдийгүй хувийн хэвшлийнхэн мөнгө босгох, хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэхэд саад болно гэсэн үг. Олон улсын байгууллагууд хөгжиж буй орны өрийн хэмжээ ДНБ-ий 40-60 хувиас хэтрэхгүй байхыг анхааруулдаг. Гэтэл манайд өрийн үзүүлэлт 71.7 хувь болоод байна.

#### Гуравдугаар хүчин зүйл. Төсвийн алдагдлыг бууруулах

Төсвийн алдагдлыг бууруулснаар улсын өрийн хэмжээг нэмэгдүүлэхгүй байх боломжтой болдог. Маастрихтийн шалгуур үзүүлэлтээр төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувийг гурав гэж үзсэн байдаг. Дэлхийн банкны мэдээгээр 2013 онд Монгол улсын төсвийн алдагдал ДНБ-ий 10 хувьтай тэнцжээ. Монголын ДНБ-д эзлэх төсвийн алдагдал өндөр байна. Дээр нь өрийг төсвөөс төлдөг гэсэн бол одоо манай улсын төсөв өрийг дарах хэмжээний илүүдэлтэй байх нь битгийн хэл, алдагдалтай явж байна. Энэ хэвээр үргэлжилсээр байх аваас эцсийн дүндээ Монголын эдийн засаг бүрэн уналтад орох бөгөөд ингэснээр улс өрөө төлж дийлэхгүй болж, хэн ч манайд боломжийн нөхцөлөөр зээл өгөхөө болино. Ийм байдалд хүрэхгүйн тулд татварын орлогын зарцуулалтыг маш сайн төлөвлөж, төрийн зардлыг хянах шаардлагатай. Улсын хөгжил цэцэглэлтэд амин чухал үүрэгтэй хувийн хэвшлийн идэвхжүүлснээр татварын орлого нэмэгдэх болно.

Урьдчилан сэргийлж чадалгүйгээр эдийн засаг бүрэн унах дээрээ тулвал “Гарц стратеги” хэрэгтэй болох бөгөөд энэ нь

ихээхэн хэмжээний зардлын хэмнэлтийг шаардана. Үүнээс болж бодит цалин буурч, нийт ард иргэдийн амьжиргаа доройтож байна. Эцэст нь бодлого боловсруулж, төсвийн шийдвэр гаргаж байгаа эрх бүхий улстөрч, түшмэдүүдийн буруу шийдвэрийн золиос болно гэсэн үг. Грек мэтийн орнууд ийм уналтад орж байсан. Гэхдээ Грек бол Европын холбооны гишүүн орон учраас ЕХ, Герман Грекийг “аварсан”. Харин Монгол бол Европын холбооны гишүүн биш. Хэн нэгэн бидний өрийг төлж, алдагдлыг бууруулна гэж хүлээлтгүй. Иймээс зөвхөн зөв бодлого биднийг аварна.

#### Дөрөвдүгээр хүчин зүйл. Мөнгөн тэмдэгийн тогтвортой байдал

Мөнгөн тэмдэгийн тогтвортой байдал, хөрвөх чадвар нь импортлогч, экспортлогчдоод урт хугацааны өсөлтийн стратегийг боловсруулах, хөрөнгө оруулагчдад валютын ханшийн өсөлтөөс үүдэх эрсдлийг бууруулах боломж олгодог. Мөн гадаад валютаар авсан өрийн дарамт өсөх аюулыг багасгаж байдаг. Үндэсний мөнгөн тэмдэг үнэгүйдэх нь гадаад валютаар зээл аван төсөл хөтөлбөрөө санхүүжүүлж байгаа компаниуд болон Засгийн газарт нэн аюултай. Учир нь, валютын зээлийг эргэж төлөх төгрөгийн дарамт нь асар нэмэгддэг. Маастрихтийн шалгуур үзүүлэлтээр үндэсний мөнгөн тэмдэгийн ханшийн хэлбэлзлийг 2,5 хувь байх нь хэвийн гэж үздэг. Энэ он гарсаар монгол төгрөгийн ханш 30 хувиар унаж, аль хэдийн инфляцид нэрвэгдчихээд байгаа эдийн засгийн төлөв байдлыг улам муутгаж байна. Дизель түлш, шатахуун, автомашин, түүний сэлбэг, аж үйлдвэрийн чухал түүхий эд материал, өргөн хэрэглээний гол бүтээгдэхүүн, тухайлбал, электрон бараа, хувцас, хүнсний бүтээгдэхүүнийг Монгол улс импортлон авч байна. Дээрээс нь дотоодын үйлдвэрлэл ч гадаадын түүхий эд, технологид суурилж байгаа нь Монголын үйлдвэрлэлийг өндөр зардалтай болгож, манай экспортын өрсөлдөх чадварыг эрс бууруулж байна. Иймээс ханшийн 30 хувийн уналт манай эдийн засгийг сөхрөөж байгаа тул сул задгай, төгрөг хэвлэх бус, мөнгөний зохих бодлогыг явуулах бодит шаардлагатай байна.

#### Үндэсний стратегийн хүрээлэнгийн байр суурь

Олборлох салбараас бусад салбарын өрсөлдөх чадварыг дэмжихийн тулд хэрэгжүүлж байгаа бодлого нь үр ашиггүй бөгөөд цаашид илүү үр өгөөжтэй, оновчтой, гол салбаруудад чиглэсэн байж олон салбартай, тогтвортой эдийн засгийн өсөлт хангагдана.

Макро эдийн засгийн тогтвортой байдлын асуудал нь ихээхэн анхаарал татаж байгаа. Ирэх жилийн төсөв, мөнгөний бодлогыг хэлэлцэх гэж байгаа өнөө үед Парламентын зүгээс нэн түргэн хариу арга хэмжээ авах шаардлагатай байгааг Үндэсний стратегийн хүрээлэнгээс цохон тэмдэглэж байна.

Дараагийн цуврал нийтлэлдээ бид дүн шинжилгээгээ үргэлжлүүлж, нөхцөл байдлыг засахын тулд юу хийж болох талаар хөндөх болно.

Үндэсний стратегийн хүрээлэн ■

## УЛС ТӨР

НАМУУДЫН УЛС ТӨР,  
НИЙГЭМ ДЭХ ҮҮРЭГ

С.ЗУЛЬФИКАР

Удирдлагын академийн Улс төр судлал,  
нийгмийн удирдлагын тэнхимийн эрхлэгч  
доктор, дэд профессор/

Улс төрийн тогтолцооны салшгүй хийгээд дийлэнх тохиолдолд улс төрийн үйл явцын цөм нь болж байдаг институт (улс төрийн байгууллага)-ууд бий. Үүний нэг нь улс төрийн нам юм. Улс төрийн намын түүхэн хөгжил нь түүний нийгэмд гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны үр дүнтэй шууд холбогддог. Нийгмийн харилцаанд тодорхой үүрэг гүйцэтгэж чадахгүй байгаа институтийг нэг бол өөрчлөгдөх эс бөгөөс нийгмийн харилцаанаас арчигдах хувь тавилан хүлээж байдаг. Улс төрийн нам нь улс төрийн харилцааны салшгүй хэсэг болоод даруй 300 гаруй жил болж байгаа хэдий ч лав ойрын жилүүдэд улс төрийн тогтолцоо, үйл явцын бүрэлдэхүүн хэсэг болсоор байх нь. Энэ нь улс төрийн нам нийгэм-улс төрийн харилцаанд тодорхой (зарим тохиолдолд тэргүүлэх) үүрэгтэй байгаатай холбоотой болов уу. Иймд улс төрийн намууд нийгэм-улс төрийн харилцаанд ямар үүрэг хүлээж, хэрэгжүүлж байгааг хэлэлцэх шаардлага тавигдаж байна. Тус өгүүллээр дамжуулан улс төрийн намын үүргийг улс төр судлалын онол, арга зүйн хандлага, ангилалын хүрээнд шинжлэн, тэдгээр үүргийг эрх зүйн харилцаагаар хэрхэн зохицуулж байгааг хэлэлцэхийг зорилгоо.

Нам “party” нь латин гаралтай (pars) үг бөгөөд хуваагдах, салах гэсэн утгатай. Тухайн үед ижил утга бүхий сект “sect” (латины secare - таслах, цавчих, хайчлах, хуваах “to sever, to cut, to divide”) гэсэн үг мөн дээрх утгаар хэрэглэгдэж байжээ. XVI зуунаас улс төрийн эсрэг үзэл санаатай хүчин бий болж, хэлбэрших үед буюу нэг хүний гарт засаглал төвлөрч түүний эсрэг эрх мэдэл бүхий бүлгүүд нэгдэн гарч ирсэнээр тэдгээр бүлгүүдийг тусгайлан нэрлэхийн тулд “party” гэдэг үг улс төрийн хэрэглээнд нэвтэрсэн. Нам судлаач Ж.Сартори улс төрийн намыг “Улс төрийн үзэл санаа, үзэл баримтлал, сонирхлоороо нэгдсэн хүмүүсийн бүлэг” гэж тодорхойлсон байна. Үүний зэрэгцээ нам гэсэн ойлголттой ойролцоо утгаар фракц “faction” гэсэн үг хэрэглэгдэж байжээ. Гагцхүү нам “party” болон фракц “faction” гэсэн үг яг ижил утга илэрхийлдэггүй. Фракц нь улс төрийн сэтгэлгээний түүхэнд удаан хэрэглэгдэж ирсэн нэр томъёо бөгөөд латины “facere (to do, to act-хийх, үйлдэх)” гэсэн үгнээс гаралтай юм. Хожим энэ үг латин хэлнээ “factio” хэмээн бичигдэх болж улс төрийн бүлгийн эмх журамгүй байдал, зохион байгуулалтыг сулруулах үйлдэл, нийгмийг хагаралд хүргэх гэсэн утгаар хэрэглэгдэх болжээ. Энэ үгний ерөнхий утга нь латин хэлээр бие даасан байх, сэхүүн зан, харгис, хэрцгий гэсэн утгыг илэрхийлдэг байна.

Хуульч Б.Чимид улс төрийн намыг дараах байдлаар энгийнээр тодорхойлсон байна. “Аливаа нам нь засаг төрийн эрх мэдлийн төлөө чадвал олонх, ядвал цөөнх, гацвал ганц суудалтай болохын төлөө ажилладаг”. Төр барихад оролцох юм уу, эсвэл түүнд шууд хяналт тавьж нөлөөлөх хувь зохиолтой учраас түүнийг улс төрийн байгууллага гэнэ. Нам бол нийгмийн удирдлагын буюу

нийтийн эрх зүйн субъект биш. Эрх зүйн үүднээс бол иргэний нийгмийн нэгээхэн хэсэг, хүн амын тодорхой хэсгийн ашиг сонирхлыг илэрхийлсэн байгууллага юм. Дээрх тодорхойлолт улс төрийн нам бол өнөө цагт нийгэм-улс төрийн харилцаанд түлхүүр үүрэгтэй болохыг илэрхийлж байна. Харин хэд хэчнээн, ямар үүрэг гүйцэтгэж байгаа нь сонирхол татах нь дамжиггүй. Үүрэг гэсэн ойлголтын хүрээнд тухайн субъект эсвэл этгээд дааж авсан, заавал хэрэгжүүлэх ёстой үйл ажиллагаа, ажил төрлийг тодорхойлж илэрхийлсэн байдаг. Тэгвэл нийгэм-улс төрийн амьдралд улс төрийн нам өөрт олгосон эрхийн хүрээнд хэрэгжүүлэх ёстой буюу дааж авсан, эсхүл тодорхой нөхцөл байдал бүрдсэн үед хэрэгжүүлэх боломжтой үйл ажиллагааг улс төрийн намын нийгэм-улс төрийн харилцаанд дахь үүрэг гэж ойлгож болохоор байна. Улс төрийн нам нь нийгэм - улс төрийн харилцаанд буюу бүхэлдээ улс орны амьдралд тав эсхүл дөрвөн үндсэн үүрэгтэй болохыг барууны улс төр судлаачид тэмдэглэжээ. Зарим тохиолдолд зургаа, долоон үүргийн талаар ч хэлэлцсэн байна. Нөгөө талаар улс төрийн намын үүргийг тодорхой тоонд хязгаарлах боломжгүй гэж үзэх хэсэг ч бий. Харин улс төрийн намын үүргийг улс төр судлалын тодорхой судлагдахуун болгон авч үзэн нийгмийн бүхий л хүрээнд дэх оролцоо, түүнээс үүдэлтэй үүргийг дараах байдлаар бүлэглэн тодорхойлж болохоор байна. Үүнд:

- Иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийн баталгаа, зохион байгуулалтын хэлбэр болно;
- Төлөөлөх – нийгмийн тодорхой хэсгийн ашиг сонирхол, хүсэл эрмэлзэлийг төлөөлнө;
- Засгийн эрх мэдлийг хэрэгжүүлэх улс төрийн өрсөлдөөнд идэвхтэй оролцогч байна;

- ▶ Нийгмийн олон талт ашиг сонирхлыг нэгтгэн, төрийн бодлого болгоно;
- Улс төрийн манлайлагчид, элит хэсгийг сонгох, бэлтгэх, байршуулах зэрэг болно.

Анхны ардчилсан сонгуулийн дараа 1992 оны нэгдүгээр сард Монгол Улсын шинэ Үндсэн хуулийг баталж түүнд “Монгол Улсын иргэд нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, эвлэлдэн нэгдэх эрхтэй”-г бататгаж намуудаас засаг төрийн сонгууль, үйл ажиллагаанд оролцох эрх зүйн үндсийг тогтоосон байдаг. Түүнээс хойш улс төрийн намууд шинээр үүсэх, өөрчлөн байгуулагдах (нийлэх, нэгдэх, тусгаарлах, салах), сонгуульд дангаар болон эвсэн оролцох зэргээр улс төрийн амьдралын мөнхийн хөдөлгөөнд байсаар иржээ. Тухайлбал, 2006 онд Улсын дээд шүүхэд бүтгэлтэй 27 улс төрийн нам байсан бөгөөд Улсын дээд шүүхэд шинэчлэн бүртгүүлээгүй долоон намыг татан буугдсанд тооцсон байна. Одоогийн байдлаар Монгол Улсад дээд шүүхэд бүртгэлтэй 22 улс төрийн нам байна. 2012 оны 10 сарын 23-ны өдөр 22 дахь улс төрийн нам (Монголын Консерватив Нам)-ыг Улсын дээд шүүх бүртгэжээ. Монголын улс төрийн намууд нийгэм-улс төрийн амьдралд ямар үүрэг гүйцэтгэж байгааг дээрх таван ангиллын хүрээнд төсөөлж эсхүл тайлбарлаж болох хэдий ч улс төрийн намуудын эрх үүргийг тодорхойлсон эрх зүйн баримт бичиг, түүнтэй уялдсан харилцааг тулгуур болгон дүн шинжилгээ хийх нь илүү зохимжтой гэж судлаачын зүгээс үзэж байгаа болно.

Иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх нь ардчилсан төр-улс, үндсэн хууль бүгд найрамдах улсын зайлшгүй шинж чанар болдог. Улс төрийн намуудыг зохион байгуулалтын бүлэг, үзэл санааны бүлэг, нийгмийн бүлэг гэж үздэг билээ. Нөгөө талаар улс төрийн зорилго, түүнийг хэрэгжүүлэх тодорхой чиг үүрэг бүхий бүлэг ч гэж үзэх нь бий. Өөрөөр хэлбэл, нийгмийн харилцаан дахь олон урьгалч үзлийг тодорхой үзэл санааны хүрээнд нэгтгэх зохион байгуулалт нь улс төрийн намаар дамжин бодит биелэл болж байдаг. Үүний тулд иргэд эвлэлдэн нэгдэж, тодорхой улс төрийн үзэл санаа, үзэл баримтлалыг суурь болгосон

улс төрийн нам байгуулдаг байна. ХХ зууны 90-ээд оны эхэнд пост-коммунист орнуудад өрнөсөн улс төрийн үйл явцын нэгэн адил Монгол Улсад олон намын тогтолцоог хүлээн зөвшөөрснөөр барууны болон зүүний чиг баримжаатай улс төрийн хүчнүүд шинээр бий болсон. Ийм ч учраас иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх, улс төрийн олон ургальч үзлийн үндсийг тавьж, нийгмийн харилцаанд төлөвшүүлэхэд улс төрийн намуудын үүрэг зайлшгүй байсан гэдэгтэй санал нэгдэж байна.

Иргэдийн эвлэлдэн нэгдэх зохион байгуулалтын нэг хэлбэр нь улс төрийн нам мөн гэдгийг Монгол Улсын Үндсэн хуулийн хүний эрх, эрх чөлөөг тунхагласан 12 дугаар бүлгийн 13.10 дугаар зүйлд дараах байдлаар тодорхойлжээ. “Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй.” Улс төрийн намын тухай хуульд улс төрийн намын тухай ойлголтыг тодорхойлохдоо түүний нийгмийн гишүүдийн эвлэлдэн нэгдэх эрхийг хангах үүргийг тодорхой зааж өгчээ. Улс төрийн намын тухай хуулийн дөрөвдүгээр зүйлийн 4.1 дэх зүйлд “Нам нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу нийгмийн ашиг сонирхол болон хувийн үзэл бодол, улс төрийн үйл ажиллагаа явуулах зорилгын үүднээс сайн дураараа эвлэлдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн.” гэсэн байна. Монгол Улсын Үндсэн хууль, Улс төрийн намын тухай хуульд улс төрийн намыг тодорхойлсон байдал нь улс төрийн нам бол тодорхой үзэл бодол, ашиг сонирхлын хүрээнд иргэдийн сайн дураараа эвлэлдэн нэгдсэн улс төрийн зохион байгуулалт болохыг бүрэн илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг хэрэгжүүлэх улс төрийн зорилго бүхий зохион байгуулалт гэж ойлгогдож байгаа юм.

Иргэд улс төрийн намын зохион байгуулалтаар эвлэлдэн нэгдэх эрхээ хэрэгжүүлэхдээ ардчилсан төр-улсын үнэт зүйлийг хүндэтгэх, Үндсэн хуулийн зарчмыг баримтлал болгохыг мөн адил хуульчилсан. Энэ нь улс төрийн нам иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийн баталгааг хангахдаа хувь хүн, төр, нийгмийн ямар үнэт зүйлийг хүлээн зөвшөөрч, ямар үнэт зүйлийг зөрчихгүй байхыг хуульчилсан зохицуулалт болжээ. Үндсэн хуульд “Нам, олон нийтийн бусад бүх байгууллага төр, нийгмийн

аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ” гэсэн бол Улс төрийн намын тухай хуульд “Монгол улсын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолыг бусниулах, үндэсний эв нэгдлийг задлан бутаргах, Үндсэн хуулийн бус аргаар төрийн эрхийг авах, хүч түрэмгийлэх, олон түмнийг үймүүлэх, айлган сүрдүүлэх, аллага, хядлага үйлдэх, яс үндэс, арьсны өнгөөр ялгаврлан гадуурхах, бусад орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын эсрэг үйл ажиллагаа, сурталчилгаа явуулах зорилгоор, түүнчлэн шашны, цэргийн болон цэрэгжсэн, фашист нам байгуулахыг хориглоно” гэж маш тодорхой зааж өгчээ. Монгол Улс ардчилсан дэглэмтэй, хүний эрх, эрх чөлөөг бүхий л талаар дээдлэсэн улс болохын хувьд улс төрийн нам байгуулах замаар иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийн баталгааг хуульчилсан бөгөөд нөгөө талаар улс орны бүрэн эрхт байдал, иргэдийн эрх, эрх чөлөөг зөрчиж болзошгүй аливаа үзэл санаа, зорилго бүхий улс төрийн зохион байгуулалт, эвлэлдэн нэгдэх үйл ажиллагаа, оролдлогыг хориглосон байна.

Төлөөллийн үүрэг - ардчиллыг өргөжүүлэх, төрийн үйл ажиллагаанд иргэд, сонгогчдын төлөөллийг хангах үүргийг улс төрийн тодорхой зохион байгуулалтаар дамжуулан хэрэгжүүлэхийг улс төрийн практик нэгэнтээ хүлээн зөвшөөрсөн байдаг. Иргэд тодорхой төлөөллийн байгууллага, этгээдээр дамжуулан улс төр, төрийн захиргааны түвшинд бодлого тодорхойлж, шийдвэр гаргах үйл явцад оролцох хэлбэрийг шууд бус ардчилал гэж нэрийдэх нь бий. Иргэд тэдний нэрийн өмнөөс бодлого тодорхойлж, шийдвэр гаргах этгээдийг сонгож, түүгээр дамжуулан өөрсдийн ашиг сонирхлыг хамгаалах, асуудлаа шийдвэрлүүлэх боломжтой байдаг. Иргэд сонгууль өгсөний дараа хууль тогтоох, шийдвэр гаргах улс төрийн институтын үйл ажиллагаанд шууд оролцох боломжгүй. Орчин үед үндэсний түвшинд улс төрийн үйл явцад иргэдийг татан орлцуулж байгаа зохион байгуулалт нь шууд бус буюу төлөөллийн ардчиллын хэлбэр юм. Учир нь үндэсний түвшинд бодлого тодорхойлж, шийдвэр гаргахад иргэдийг шууд оролцуулах цаг хугацаа, орон зай, зохион байгуулалтын боломж хязгаарлагдмал байдаг нь шууд



Эрчим хүч хэмнэлтийн шийдвэр гаргахад тулгардаг


## ГОЛ ХӨДӨЛГӨГЧ БА БЭРХШЭЭЛ



## Шнайдер Электрикийн Судалгааны үр дүн

2014 оны 9 сард зохион байгуулагдсан Франц Монголын Эдийн Засгийн Чуулга уулзалтын үеэр Эрчим хүч, Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага аж ахуйн нэгжүүдийн 150 төлөөлөөс авсан судалгааг хүргэж байна

### БЭРХШЭЭЛҮҮД



Технологи болон мэдлэгийн дутмаг байдал нь эрчим хүч хэмнэлтийн шийдвэр гаргахад тулгардаг хамгийн гол бэрхшээлүүд гэж 55% нь хариулжээ

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

2014 онд Эрчим хүчний зохицуулалтад



## ЦААШДЫН ХАНДЛАГА



2015 онд Эрчим хүчний зохицуулалтад 2014 онтой ижил эсвэл илүү хэмжээтэй хөрөнгө оруулалт хийнэ

## ТӨРИЙН БОЛОН ХУВИЙН БАЙГУУЛЛАГЫН ЯЛГАА



### Эрчим хүчний зохицуулалт, хэмнэлтийн хамгийн том боломжууд хаана байна вэ?



70% Судалгаанд хамрагдсан байгууллагуудын 70% эрчим хүчний Аудитад хандаж байгаагүй бол 12% хандаж байсан гэж мэдэгджээ

Эрчим хүчний үр ашигтай хэрэглээний талаар нэмэлт мэдээлэл авах бол [www.schneider-electric.mn](http://www.schneider-electric.mn) -д зочилно уу

**“ЭНТРЕПРЕНЁР БОЛ ХАВЦЛААС ҮСРЭЭД, ДАЛАВЧ  
ХИЙЖ НИСДЭГ ХҮН ЮМ”**

*РЕЙД ХОФФМАН, ЛИНКЕДИНЫГ ҮНДЭСЛЭГЧ*

# **МОНГОЛЫН ЭНТРЕПРЕНЁРУУДЫН НЭГДСЭН ЧУУЛГАН 2014**

**ИРЭЭДҮЙГЭЭ БҮТЭЭЦГЭЭЕ!**

**УЛААНБААТАР ХОТ, 2014 ОНЫ 11САРЫН 10-11  
БЕСТ ВЕСТЕРН ТУУШИН ЗОЧИД БУУДАЛ**

**МОНГОЛЫН ЭНТРЕПРЕНЁРУУДЫН ХАМГИЙН ТОМ  
ЦУГЛАРАЛТАД ИР, ҮЗ, ШИНЭ ДАВАЛГААГ МЭДЭР!**

*Зохион байгуулагчид:*



*Хамтран зохион байгуулагчид:*



*Хэвлэл мэдээллийн ивээн тэтгэгчид:*










# Office 365

Office 365 гэдэг нь Microsoft Office програмын онлайн хувилбар буюу үүлэн тооцоололд суурилсан хувилбар юм. Office 365-ийн бүрэлдэхүүнд бидний сайн мэдэх Office-ийн үндсэн програмууд болох Word, Excel, Power Point, Outlook-ээс гадна Lync онлайн бизнес мессенжер, Exchange онлайн бизнес имэйл сервер, Sharepoint онлайн документ менежментийн програмууд багтдаг. Office 365 нь онлайн сервис учраас хэзээ ч, хаанаас ч компьютер, нөүтбүүкээс гадна iPhone, iPad, Windows phone, Android phone гээд бүх төрлийн ухаалаг төхөөрөмж, вэб хөтчөөр дамжуулан ашиглах боломжтой.

Та өөрийн байгууллагынхаа хэрэглээнд тохируулан Business Essentials, Business, Business Premium багцуудаас сонгоорой. Microsoft-ийн дата центрээс хэрэглэгчдэд шууд хүрдэг тул 99.9%-ийн найдвартай ажиллагаа, нууцлал хамгаалалт, байнгын шинэчлэлт, 24/7 тусалцаа үйлчилгээтэйгээр танд хүрнэ.

Office 365 Business Essentials 5 Т.Н хэр/сар	Office 365 Business 8,25 Т.Н хэр/сар	Office 365 Business premium 12,50 Т.Н хэр/сар
 300 <small>хүртэлх хэрэглэгчдэд</small>	 300 <small>хүртэлх хэрэглэгчдэд</small>	 300 <small>хүртэлх хэрэглэгчдэд</small>
Office Online	Office Online	Office Online
File storage and sharing	File storage and sharing	File storage and sharing
Business-class email	Office for smartphones	Business-class email
Unlimited online meetings	Office for tablets	Office for smartphones Office for tablets
Intranet site for your teams	Full, installed Office applications	Unlimited online meetings
Social networking		Intranet site for your teams Full, installed Office applications Social networking
	Desktop versions of: 	Desktop versions of: 

Office 365 үйлчилгээний демо хувилбарыг туршихыг хүсвэл:  
<https://office.microsoft.com>